

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН  
2018 ОНЫ 05 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2018.06.05

Сүхбаатар сум

**Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

**1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 5 дугаар сард 1 удаа хуралдаж, 11 асуудал хэлэлцэн 12 тогтоол баталлаа. Үүнд:

-Сэлэнгэ аймгийн Ерөө, Хүдэр сумын нутаг дэвсгэрт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй “Болд төмөр-Ерөө гол” ХХК, “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХК-ий үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, аймаг, сум орон нутагтай хамтран ажиллаж буй байдлыг шалган танилцаж дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг томилж, санал дүгнэлт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, шийдвэрийн төслийг боловсруулан 2 дугаар улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахаар тогтов.

-Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдан ирсэн цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн тооны дээд хязгаарт багтаан 2018 онд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн сумдын хуваарийг баталж, Ерөө сумаас 17, Орхонтуул сумаас 20, Хүдэр сумаас 8, Сант сумаас 5 иргэнийг хамруулахаар тогтоолоо.

-Зарим байгууллагуудад олон жил ашигласан, цаашид албан ажилд ашиглах боломжгүй, ашиглалтгүй үндсэн хөрөнгүүдийг актлах, тээврийн хэрэгсэл, гүний худгийн барилга, газар зэргийг балансаас балансад шилжүүлэхээр, Мандал сумын Цагдаагийн хэлтэс, “Урсгал-Ус” ХХК, “Цант-Орхон” ХХК-ий үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, сэргээн засварлах боломжгүй болсон автомашинуудыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг тогтоолоо.

-Шаамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв үүсч байгуулагдсаны 60 жилийн ойг 2019 оны 09 дүгээр сард, Шаамар сумын “Бүжинхэн” 18 дугаар цэцэрлэг үүсч байгуулагдсаны 50 жилийн ойг 2018 оны 10 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлэхээр тогтоол гаргалаа.

-Байгууллага, сум орон нутгаас ирүүлсэн хүсэлтийг харгалзан үзэж Сүхбаатар сумын Г.Бумцэндийн нэрэмжит Улсын тэргүүний 1 дүгээр сургуулийн 80 жилийн ойг тохиолдуулан тус сургуулийг “Алтан гадас” одонгоор шагнуулахаар, газар тариалангийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж салбартаа шинэ технологийг нэвтрүүлэн хүн ардыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах үйлсэд оруулсан хувь нэмрийг нь үнэлэн Мандал сумын иргэн, ахмад настан Доржпаламын Арвинг Монгол Улсын Хөдөлмөрийн баатар цолоор шагнуулахаар, үндэсний сурын спортыг хөгжүүлэх үйл хэрэгт олон жилийн хүч хөдөлмөрөө зориулж идэвх санаачилга гарган ажиллаж, орон нутагт үйлдвэр байгуулан нум сум үйлдвэрлэж дотоодын хэрэгцээг хангаж залуу харваачдыг сурган бэлтгэж улс, аймгийн уралдаан тэмцээнүүдэд амжилттай оролцуулан үндэсний сурын спортын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж байгааг үнэлж Жамбаагийн Сүхбаатарыг Монгол Улсын Гавьяат дасгалжуулагч цолоор, боловсролын байгууллагад тасралтгүй 48 жил үр бүтээлтэй ажиллаж ирээдүй болсон хүүхэд залуусыг сурган хүмүүжүүлэх нэр хүндтэй үйлсэд хүч хөдөлмөрөө зориулсныг нь үнэлж Бандийн Адъяаг Монгол Улсын Гавьяат багш цолоор шагнуулахаар уламжилснаас гадна эрхэлсэн ажилдаа үр бүтээл, идэвх санаачилга гарган ажилласан зарим хүмүүсийг одон, медалиар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав. Үүнд: Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 9,

Алтан гадас одонгоор 43, Цэргийн гавьяаны одонгоор 3, Хөдөлмөрийн хүндэт медалиар 29 хүнийг шагнуулахаар тогтоолоор уламжлав.

Мөн хурлаар сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээллийг ээлж дараалан сонсон ажиллаж байгаа. Энэ сарын хуралдаанд Зүүнбүрэн, Цагааннуур сумын Засаг даргын мэдээлэл, “Гавшгай Ус”, “Цант Орхон” ОНӨААТҮГ-уудын 2017 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцлээ.

## **2. Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх энэ сарын 14, 15-ны өдрүүдэд Сэлэнгэ аймагт ажиллаж, Зүүнбүрэн сумын “Газар агро” ХХК-ий махны хэвшлийн үхрийн аж ахуй, “Арвин хур” ХХК-ий усалгаатай тариалан, “Алтан тариа” ХХК-ий сүүний үхрийн фермийн аж ахуй, Хушаат сумын “Элит үр” ХХК-ий төмсний тариалалт, үр үйлдвэрлэлт, Сант сумын “Монгол газар шим” ХХК-ий усалгаатай тариалалтын явц, Сайхан сумын Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаатай танилцлаа. Сэлэнгэ аймаг улсын хэрэгцээт үр тарианы тэн хагасыг дангаараа үйлдвэрлэдэг бүс нутаг учир “Эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хослуулан хөгжүүлэх” зорилт дэвшүүлж бодлого боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байгаагаа аймгийн Засаг даргаас мэдээлж, “Элит үр” компаний туршлага дээр тулгуурлан “Сэлэнгэ” нэрийг тодорхойлсон шинэ үртэй болохоор ажиллаж байгаагаа танилцууллаа.

Аймгийн хэмжээнд 2018 онд нийт 185922 га талбайд үр тариа, төмс, хүнсний ногоо тариалахаас 6-р сарын 5-ны байдлаар 177795 га талбайд тариалж, тариалалтын явц 95,6 хувьтай байна. Үүнээс үр тариа 142554.9 га, улаанбуудай 134544 га, арвай 819 га, овьёос 3691 га, гурвалжин будаа 3497 га, цагаан будаа 4 га, тэжээлийн ургамал 12991 га, тосны ургамал 22249 га, төмс 2189 га, хүнсний ногоо 1886 га-д тус тус тариалсан байна.

Аугаа их эх орны дайны Ялалтын 73 жилийн ойг тохиолдуулан Алтанбулаг суманд байрлах Зөвлөлтийн дайчдын хөшөөнд цэцэг өргөж хүндэтгэл үзүүлэх уламжлалт үйл ажиллагаа энэ сарын 05-ны өдөр зохион байгуулж, аймгийн Засаг дарга Ш.Оргил, ОХУ-аас Дархан-Уул аймагт суугаа Ерөнхий консул Д.А.Цыденишиевич болон Алтанбулаг сум, Хиагтын районы удирдлагууд, Орос, Монголын чөлөөлөх дайны ахмад дайчид, төр захиргааны ахмад ажилтнууд, нутгийн ард иргэд оролцож, Алтанбулаг сумын сургуулийн сурагчид, “Сэлэнгийн долгио” чуулгын уран бүтээлчид ая дууны мэндчилгээ дэвшүүллээ.

2018 оны нэгдүгээр ээлжийн хугацаат цэргийн албан татлагыг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны маш нууц МН/213 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын маш нууц МН/46 дугаар тушаал, Батлан хамгаалахын сайд, Сэлэнгэ аймгийн Засаг даргатай 2018 онд хамтран ажиллах гэрээ, аймгийн Засаг даргын 2018 оны А/121 дүгээр захирамж, Цэрэг татлагын товчооны даргын А/26 дугаар тушаалыг тус тус үндэслэн 4 дүгээр сарын 25-ны өдрөөс 5 дугаар сарын 4-ний өдрүүдэд Мандал, Сайхан, Ерөө, Сүхбаатар сумдын цэрэг татлагын байруудад зохион байгуулж, 2018 оны нэгдүгээр ээлжийн хугацаат цэргийн албаны татлагын эрүүл мэндийн үзлэгт хамрагдвал иргэдийн 83,8 хувь нь хамрагдаж, Зэвсэгт хүчин, Хилийн цэргийн анги салбаруудад хүлээлгэн өгөх хяналтын тоог 100 хувь биелүүлсэн.

Аймгийн төрийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн сул орон тооны захиалгын дагуу төрийн албаны мэргэшлийг энэ сарын 3-ны өдөр зохион байгуулж, дэс түшмэлийн 21 ажлын байранд 28, туслах түшмэлийн 25 ажлын байранд 77 иргэн бүртгүүлж, дэс түшмэлийн ажлын байранд 15 иргэн, туслах түшмэлийн ажлын байранд 21 иргэн тэнцсэн бөгөөд шалтгалтын явцыг Монгол Улсын Төрийн албаны зөвлөлтэй дүрст төхөөрөмжөөр холбогдон хяналт тавьж явууллаа. Мөн Хүдэр сумын Засаг даргын Тамгын газрын даргын сонгон шалгаруулалтыг энэ сарын 24-ний өдөр зохион байгуулсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр орон нутгийн болон тусгай зориулалтын

шилжүүлгийн байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга, нягтлан бодогч нартай уулзалт хэлэлцүүлэг хийж, аймгийн Засаг дарга Ш.Оргил үүрэг чиглэл өглөө.

Аймгийн төв Сүхбаатар хотод энэ сарын 18-ны өдөр “Төв буюу Хангайн бүс-2018” үсчин гоо засалчдын тэмцээн амжилттай явагдаж өндөрлөлөө. Тэмцээнийг Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар, Монголын үсчин гоо засалчдын холбоо, аймгийн үсчин гоо засалчдын холбоо, Lakme Inspired haircare хамтран зохион байгуулсан бөгөөд 7 аймгийн 88 үсчин, гоо засалчид 9 төрөлд ур чадвараараа өрсөлдөж, Дархан-Уул аймаг давхардсан тоогоор 21 хүн оролцож алтан медаль 2, мөнгөн медаль 3, хүрэл медаль 5 хүртэн “Шилдэг аймаг”-аар шалгарч, Шилдэг үсчингээр Баянхонгор аймгийн Б.Ууганцэцэг, “Шилдэг эмэгтэй модель”-оор Баянхонгор аймгийн Н.Долгормаа, “Шилдэг эрэгтэй модель”-оор Дархан-Уул аймгийн Э.Өсөхбаяр нар шалгарлаа.

### **Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар:**

Монгол Улсад Хэмжилзүйн байгууллага үүсч хөгжсөний 95 жил, Стандартчиллын 65 жил, Сорьцын хяналтын 55 жилийн ойн баярын хүрээнд Дархан уул аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтэстэй хамтран “Хишиг өдөр” арга хэмжээг зохион байгуулж, Шаамар сумын Дулаанхаан тосгонд үйл ажиллагаа явуулж буй 3 аж ахуйн нэгжийн жинг баталгаажуулж, Номгон тосгоны ШТС-ын 4 түгээгүүрт шалган баталгаажуулалт хийж харилцан туршлага соүлилцлоо.

Тайлант сард Баянгол, Мандал, Сүхбаатар, Сайхан, Баруунбүрэн, Сант, Түшиг, Цагааннуур, Шаамар сум, Дулаанхан, Түнхэл тосгоны 63 аж ахуйн нэгж, иргэний 34 хүнсний дэлгүүр, 10 минимаркет, 3 хүнсний мухлаг, 3 зоогийн газар, 2 кафе, 1 цайны газар, 2 зочид буудал, 1 амралтын газар, 4 баар, 1 худалдааны агуулах, 1 авто үйлчилгээ, 1 авто угаалга, нийт 63 үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олголоо. Мөн Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж буй 4 цахим тоглоомын газарт стандартын хэрэгжилтэнд шалгалт хийж, Мандал сумын 3 авто үйлчилгээ, засварын газар, 1 авто угаалгын газарт холбогдох стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж 1 авто үйлчилгээ, 1 авто угаалгын газарт гэрчилгээ олголоо.

Стандартын салбар сангаас 8 аж ахуйн нэгж, байгууллага иргэний 9 нэрийн 13 стандартын захиалгыг авч, 11 аж ахуйн нэгж, байгууллага, 9 иргэнд 17 нэрийн стандартаар борлуулалт хийж, арга зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлсэн.

Мөн ээлжит баталгаажуулалтаар Мандал, Баянгол, Сайхан, Түшиг, Зүүнбүрэн, Цагааннуур, Шаамар сумдад ажиллаж, худалдаа, үйлчилгээний газруудын 175 жин, 10 туухайг шалган баталгаажуулж, массын хэмжлийн төрлөөр эмийн сангуудын 6 жинд шалгалт тохируулга хийлээ.

Цахилгааны хэмжлийн төрлөөр Сүхбаатар сумын айл өрхийн 13 ширхэг нэг фазын электрон тоолуур баталгаажуулалт хийж, эзэлхүүн хэмжлийн төрлөөр сумдын 51 шатахуун түгээх газрын 179 түгээгүүрийн шингэн хэмжигчийг ээлжит баталгаажуулалтанд хамрууллаа.

### **Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

Монгол банкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар батлагдсан “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн ач холбогдол, хэрэгжилтийг олон нийтэд сурталчлах, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдүүдэд багаас нь санхүүгийн боловсрол олгох, мөнгөө хэрхэн зөв зохистой зарцуулж хуримтлуулах, чадвар болон итгэл үнэмшил зэрэг санхүүгийн анхан шатны мэдлэг олгох чиглэлээр танхимын сургалтуудыг Мандал, Сайхан, Сүхбаатар сумын ахлах ангийн сурагчдад явуулж, гар зураг, илтгэл, ЭССЭ бичлэгийн уралдаанууд, “АХА” тэмцээнийг зохион байгууллаа.

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор жил бүрийн 5 сарын 2 дахь 7 хоногийг Монголын татвар төлөгчдийн өдөр болгон тэмдэглэх болсноор 11 дэх жилдээ “Эх оронч үзэл татвар төлөхөөс эхлэнэ” уриан дор тэмдэглэлээ. Татвар төлөгчдийн өдрүүдээр Сэлэнгэ аймгийн ЕБС-ын сурагчдын дунд гар зураг, зохион бичлэг, Монгол үндэсний тоглоом бүтээх бүтээлийн уралдаануудыг зохион байгуулснаас гар зураг-94, зохион бичлэг -286, Монгол үндэсний тоглоом -32 бүтээл ирүүлж 1,2,3 байр эзлүүлж шалгарсан бүтээлийг шагнаж урамшууллаа. Мөн ЕБС-ын сурагчдад Цахим төлбөрийн баримтын талаар хичээл зааж 1539 сурагч хамрагдаж сурагчдын дунд “1 АСУУЛТ 1000 ТӨГРӨГ” асуулт хариултын тэмцээнийг зохион байгууллаа.Татвар төлөгчдийн өдрүүдийг Сайхан суманд үйл ажиллагаа явуулж буй Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран тэмдэглэсэн нь ихээхэн үр дүнтэй болсон ба “Хөтөлийн цемэнт шохой” ХК-ний ажилчдад татварын хуулиар ажлын байран дахь сургалтыг хийлээ.

2017 оны жилийн эцсийн өрийн үлдэгдлийн баталгаажуулалт аймгийн хэмжээнд 11188 татвар төлөгчийн өрийн үлдэгдэл баталгаажуулахаас 7230 татвар төлөгчийн өрийн үлдэгдлийг баталгаажуулан 64,6 хувьтай цаашид үргэлжлүүлэн эхний хагас жилд багтаан дуусгахаар ажиллаж байна.

### 1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
<b>1. Орон нутгийн төсвийн нийт орлого</b>		<b>26.428.262.5</b>	<b>29.371.949.4</b>	<b>111.1</b>
1.1	<b>Орон нутгийн төсвийн орлого</b>	<b>4.794.062.4</b>	<b>5.729.842.4</b>	<b>119.5</b>
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	3.541.372.9	4.045.530.1	114.2
	Сумдын төсвийн орлого	1.252.689.5	1.684.312.3	134.5
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	2.550.000.0	2.550.000.0	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	17.388.123.2	17.388.123.2	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	885.346.0	804.703.2	90.9
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	673.420.6	2.761.970.3	410.1
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	137.310.3	137.310.3	100.0
<b>2. Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>		<b>26.428.262.5</b>	<b>22.127.160.8</b>	<b>83.7</b>
2.1	<b>Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>	<b>26.428.262.5</b>	<b>22.127.160.8</b>	<b>83.7</b>
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	3.604.201.3	2.765.828.4	76.7
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	558.758.7	60.231.6	10.8
	<b>Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага</b>	<b>5.490.552.3</b>	<b>40.47.706.1</b>	<b>73.7</b>
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	410.000.0	120.466.2	29.4
	Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт	50.000.0	-	-
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	419.030.6	149.207.0	35.6
	Халамжийн сан	3.006.619.1	2.595.145.5	86.3
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	1.496.752.6	1.077.967.1	72.0
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	108.150.0	104.920.4	97.0
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	15.649.750.3	14.260.333.2	91.1
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	1,124,999,9	993,061,4	88,3
	<b>3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг</b>		<b>19,275,997,2</b>	<b>18,861,842,8</b>
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	1,650,472,9	1,650,472,9	100,0

3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	510,692,6	219,447,6	43,0
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	43,776,4	43,776,4	100,0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	108,002,8	108,002,8	100,0
	Хөрөнгө оруулалтын зардалд	358,913,4	67,668,4	18,9
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	374,653,5	251,744,1	100,0
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	373,562,9	250,653,5	67,1
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	1,090,6	1,090,6	100,0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	15,627,404,3	15,627,404,3	100,0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	1,112,773,9	1,112,773,9	100,0
3.6	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	16,740,178,2	16,740,178,2	100,0
	- Ерөнхий боловсролын сургууль	8,265,446,6	8,265,446,6	100,0
	- Хүүхдийн цэцэрлэг	4,318,381,8	4,318,381,8	100,0
	- Соёлын байгууллага	1,208,215,7	1,208,215,7	100,0
	- Биеийн тамир спортын байгууллага	530,085,4	530,085,4	100,0
	- Эрүүл мэндийн байгууллага	2,139,018,2	2,139,018,2	100,0
	- Газрын кадастрын байгууллага	140,766,3	140,766,3	100,0
	- Хүүхдийн байгууллага	138,264,2	138,264,2	100,0
<b>4. Тусгай сангуудын зарлага</b>		<b>438,609,6</b>	<b>30,228,8</b>	<b>69,9</b>
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	438,609,6	30,228,8	69,9

## 2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2018 IY- сар	2018 V- сар	2018- V 2018-IY /төгрөгөөр/
<b>1.ХҮНСНИЙ БАРАА</b>				
<b>1</b>	<b>ТАЛХ, ГУРИЛ, БУДАА</b>			
	Гурил /савласан, кг/	1 100	1 100	100.0
	Талх /орон нутгийн, ш/	1 100	1 100	100.0
	Нарийн боов /кг/	2 500	2 500	100.0
	Будаа /кг/	2 400	2 400	100.0
	Элсэн чихэр /кг/	2 200	2 200	100.0
<b>2</b>	<b>МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН</b>			
	Хонины мах /кг/	6000	6 000	100.0
	Үхрийн мах /кг/	7 500	7 500	100.0
	Адууны мах /кг/	5 500	5 800	105.5
	Ямааны мах /кг/	5000	5 500	110.0
	Дотор мах, цувдай /цусгүй/	3 500	3 500	100.0
	Хиам /чанасан, кг/	10 000	10 000	100.0
<b>3</b>	<b>СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ</b>			
	Сүү /задгай, л/	1 500	1 500	100.0
	Сүү / савласан, л/	2 600	2 600	100.0
	Тараг /задгай, л/	1800	1 800	100.0
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	12 000	12 000	100.0
	Айраг /л/	3 500	3 500	100.0
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	350	100.0
<b>4</b>	<b>БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС</b>			



	Ургамлын тос /л/	3 800	3 800	100.0
	Өөхөн тос /кг/	1 500	1 500	100.0
	Шар тос /кг/	15 000	15 000	100.0
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
<b>5</b>	<b>ХҮНСНИЙ НОГОО</b>			
	Төмс /кг/	1 200	1 200	100.0
	Лууван /кг/	1 200	1 200	100.0
	Манжин /кг/	1 500	1 500	100.0
	Байцаа /кг/	1 500	1 500	100.0
	Сонгино /кг/	1 500	1 500	100.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	3 500	100.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 300	2 300	100.0
<b>7</b>	<b>ШАТАХУУН</b>			
	Бензин А - 80	1 580	1 530	96.8
	Бензин А - 92	1 735	1 735	100.0
	Дизелийн түлш	2 020	2 020	100.0

### Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран Хүүхдийн эрхийг хамгаалах Олон улсын өдрийг тохиолдуулан хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн эсрэг бүх төрлийн хүчирхийллийг бууруулахад олон нийтийг татан оролцуулах, хуулийн хэрэгжилтийг сурталчилан таниулах, талуудын үүрэг оролцоо нэмэгдүүлэхэд чиглэгдсэн “Хамгаалагдсан хүүхэд” сарын аяныг 2018 оны 05 дугаар сарын 17-ний өдрөөс 06 дугаар сарын 17-ны өдрүүдэд зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын захирамж, Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ажлын сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор “Ёс зүйн зөрчилгүй хамт олон” аяныг аймгийн хэмжээнд 2018 оны 06 дугаар сарын 15-наас 07 дугаар сарын 02-ны өдөр хүртэл зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаал тус батлагдан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Хүний эрхийн үндэсний комисс хамтран “Хүний эрхийн-театр” арга хэмжээг хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгууллаа.

2018 оны эхний 05 дугаар сарын 01-ний байдлаар гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 319, гэмт хэрэг 249 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гомдол мэдээлэл 26.5%-иар буурсан, гэмт хэрэг нь 13.2%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Хууль зүйн салбарын нээлттэй бодлогыг хэрэгжүүлэх, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн болон албаны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу албаны үйл ажиллагааг сурталчлах, иргэдэд мэдээ, мэдээлэл өгөх зорилгоор “Нээлттэй хаалганы өдөрлөг” арга хэмжээг Сүхбаатар сумын “Олон улсын худалдааны төв”-ийн талбайд 05 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан. Тайлант сард шинжээч эмч нар нь нийт 365 шинжилгээ хийснээс хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг шинжилгээ 272 удаа / хүнд 9, хүндэвтэр 7, хөнгөн 125, гэмтэл тогтоогдоогүй 47, гэмтлийн зэрэгт хамаарахгүй 84/, магадлан шинжилгээ 81 удаа хийж ажилласан байна.

Тайлант сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 504 бичиж, лавлагаа 2 олгож үйлчилж, аймгийн хэмжээнд төрсний бүртгэл 167, гэрлэлтийн бүртгэл 35, гэрлэлт цуцалсны бүртгэл 19, эцэг тогтоолт 9, овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 10, нас баралт 62 бүртгэж, иргэний үнэмлэх 579 иргэнд дахин болон шинээр, гадаад паспорт 115 иргэнд олгож, аймаг хот руу бүр мөсөн шилжин явсан 182, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 180, хот доторх шилжилт хөдөлгөөн 577 тус тус хийсэн байна.

Эрх зүйн албан бус сургалт сурталчилгааны ажлын хүрээнд “Захиргааны ерөнхий хууль”, “Зөрчлийн тухай” хууль, “Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхэд хамлааллын тухай”, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай” “Гэр бүлийн тухай” хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын ерөнхий хууль, зэрэг сэдвүүдээр сургалт, сурталчилгааны ажлуудыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, сумдын төрийн албан хаагчид болон Алтанбулаг, Ерөө, Мандал, Зүүнбүрэн, Хушаат сумдуудад зохион байгуулж нийт 1223 иргэнийг хамрууллаа.

### **Архивын чиглэлээр:**

Архивын ерөнхий газраас архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийг байгууллага болон төрийн архивын үйл ажиллагаанд хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд, баримт бичиг зохион бүрдүүлэхэд тавигдах үндсэн шаардлага, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх тухай МУ-ын Засгийн газрын 2017 оны 4 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн ажиллахад анхаарах асуудлуудын талаар онлайн сургалтыг 05 сарын 25-нд 14-17 цагийн хооронд зохион байгуулсан бөгөөд энэхүү сургалтанд аймгийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийг хамруулсан.

Иргэд, албан байгууллагын хүсэлтийн дагуу нийт 243 архивын хуулбарыг гаргаж үүнээс цахимаар-97, цаасан суурьтай баримтнаас-48, мастер хувиас-98, магадалгаа, тодорхойлолт-40-ыг тус тус гаргаж үйлчилсэн байна.

### **Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

#### **1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр:**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, эх хэлээ эрхэмлэн дээдлэх, үндэсний бичиг үсгийн баярыг үндэсний хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх, ирээдүй хойчдоо өвлүүлэн үлдээх зорилгоор үндэсний бичиг үсгийн баярыг “ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСЭГ-ТУСГААР ТОГТНОЛ” уриан дор 5-р сарын 04-ний өдөр аймгийн төв Партизаны талбайд зохион байгууллаа. Энэ үеэр “Өв соёл” судар ном, монгол хэл шинжлэлийн ном, хүүхдийн номын үзэсгэлэн, уралдаан тэмцээн, Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулдаг монгол бичгийн клубуудын үйл ажиллагааг танилцуулан сурталчлах, монгол бичгийн уран бичлэгийн бүтээлийн үзэсгэлэн гаргаж, номын худалдаа хийх зэрэг ажлууд хийгдэж, “Үндэсний бичиг үсэг, өв соёлоо эрхэмлэгч байгууллага” шалгаруулах аянг зохион явуулж нийт 16 төрийн болон аж ахуйн нэгж байгууллага идэвхи санаачлагатай оролцож 1 дүгээр байранд Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн Тамгын газар 2-р байранд Хилийн 0101-р анги 3-р байранд Нийгмийн даатгалын хэлтэс 4-р байранд Сүхбаатар сумын Улсын тэргүүний 1-р сургууль, 5-р байранд Сэлэнгэ аймгийн Прокурорын газар тус тус шалгарсан.

“Шилдэг үндэсний өв тээгч” буюу зөв цэвэр бичигтнээр Улсын тэргүүний 2-р сургуулийн 12-р ангийн сурагч Н.Хатан-Эрдэнэ “Шилдэг үндэсний бичиг үсгийг сонордуулагч” буюу түргэн, тод уншигчаар Улсын тэргүүний 4-р сургуулийн 12-р ангийн сурагч Б.Амина “Шилдэг үндэсний соёлын өвийг түгээгч”-ээр Улсын тэргүүний 4-р сургуулийн Монгол бичгийн багш Алтанхүү нар тус тус шалгарсан.

“Ойн хомсдол, хот суурин газрын ногоон байгууламжийн тухай болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах” үйл хэрэгт хүүхдийн бүтээлээр дамжуулж, олон нийтэд нөлөөлөх, сурагчдын авьяас чадварыг нээж, урамшуулах зорилгоор орон нутагтаа 500000 төгрөгний шагналын сан бүхий уралдааныг 4 дүгээр сарын 13-наас 5 дугаар сарын 13-ны хооронд зарлан 30 сургуулийн 124 гэрэл зураг, 28 сургуулийн 75 нийтлэл ирүүллээ.

Энэ сарын 09-11-ний өдрүүдэд Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн сумын цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулиудад зөвлөн туслах чиглэлээр ажиллаж, сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт, анги дүүргэлт, багшийн хүрэлцээ хангамж, сонгон гүнзгийрүүлж судлах хичээлийн

төлөвлөгөө, хичээлээс гадуурх ажлын зохион байгуулалт, хэрэгжилт, үр дүн, сургалтын орчны тохижилт, засвар үйлчилгээ, эрүүл ахуй, сурагчийн дүрэмт хувцас, сурах бичгээр хангагдсан байдал, хүрэлцээ хангамж, дотуур байр, цэцэрлэг сургуулийн гал тогоо, үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, хөрөнгө оруулалт, төсөв санхүүгийн үйл ажиллагаа, хүүхэд харах үйлчилгээтэй танилцаж нийт 73 хичээл, үйл ажиллагааг ажиглаж, 303 багш, удирдах ажилтнуудад зөвлөгөө өглөө.

Тайлант сард “Аваргын гараа” Сүхбаатар сумын 5-р сургуулийн нэрэмжит үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулж 4 сумын 11 сургуулийн 80 гаруй өсвөрийн бөхчүүд 2 насны ангиллаар, Аймгийн хурц арслан Г.Жаргалтулга агсаны нэрэмжит Үндэсний бөхийн өсвөр, залуучуудын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 16 сум 3 тосгоны 180 гаруй бөхчүүд хурд хүчээ сорилоо. Мөн аймгийн аварга шалгаруулах шагайн харвааны тэмцээнд 27 багийн 200 гаруй харваачид цэц мэргэнээ сорьж, шилдгүүдээ шагнаж урамшууллаа.

## **2.Эрүүл мэндийн талаар:**

Чихрийн шижингийн гаралтай хүндрэлүүдийн нэг болох нүдний торлогийн эмгэгийн улмаас үүсэх сул хараа, сохролыг бууруулах зорилгоор ангаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн нүд судлалын тэнхимийн эмч нарын багтай хамтран нүдний хүндрэлийг илрүүлэх үзлэгийг зохион байгууллаа. Үзлэгт Нэгдсэн эмнэлгийн дотоод шүүрлийн кабинетын хяналтанд байгаа 523 үйлчлэгчдийн 482 буюу 92 хувийг хамруулан, нүдний хүндрэлийг илрүүлэх асуумж, судалгааг авч, нүдний уг дурандаж, үзлэг хийсэн. Нүдний хүндрэлийн 6 тохиолдлыг илрүүлж, дараагийн шатны эмнэлэгт шилжүүлж, мэс заслын хагалгаанд оруулахаар болсон.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн сувилахуйн албатай хамтран сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор “Сувилагч нарын сувилгааны түүх хөтлөх ур чадварыг сайжруулах” вакумжуулсан сургалтыг 4 ээлжээр 17 сум, 6 тосгоны Эрүүл мэндийн төвийн нийт 24 ахлах сувилагчийг сургаж сургагч багшаар бэлтгэсэн. Түнхэл тосгонд халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн үйл ажиллагааг зохион байгуулж нийт 1143 хүнийг үзлэгт хамруулсан. Эмнэлгийн тусгай зөвшөөрөлийн комиссын хурлыг 2018 оны 5 дугаар сарын 2-ны өдөр зохион байгуулж нийтдээ 15 байгууллагын тусгай зөвшөөрөлийг сунгасан.

## **3.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:**

2018 оны 04-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 863 байсан бол 277 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 132 ажлын байранд 112 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 166 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 862 болсон байна.

Нийгмийн халамжийн сангаас 5-р сарын байдлаар 32218 иргэнд 5,865,399.6 төгрөгийг олгоод байна.

Европын холбооны санхүүжилттэй Монгол Улсад ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх (SECiM) төслийн санхүүжилтээр сумдын нийгмийн бодлого, хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтнүүдэд 3 удаагийн шаталсан мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулахаас эхний шатны сургалтыг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх бэлтгэх сургалтыг 05 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд зохион байгуулсан.

“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 15 сум 5 тосгоны 34 иргэний төслийг дэмжиж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 92500.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон.

Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд 17 сум 6 тосгодын ядуурлаас гаргах өрхийн гишүүдээс 59 иргэнийг сонгон авч төмс хүнсний ногоо тариалах үр бордоо, тоног төхөөрөмж, үйл ажиллагааны зардалд зориулан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 29500.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлээд байна.



Нийтийг хамарсан ажлаар Сүхбаатар сумын 71 иргэнийг мод тарих, Партизаны талбайн хагарсан плита солих, 1, 2, 3, 8-р багуудын үерийн далан цэвэрлэх, сэргээн засварлах ажилд түр ажлын байраар хангаж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 5684.0 мянган төгрөгийг зарцууллаа.

“Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт Түшиг, Цагааннуур, Шаамар, Сайхан сум Дулаанхаан тосгоны 5 ахмад настанг хамруулж 13500.0 мянган төгрөгийг зарцуулсан.

#### **4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:**

Олон Улсын Гэр бүлийн өдрөөр “Миний гэр бүлийн нэг өдөр”-ийг тохиолдуулан эссэ бичлэгийн уралдааныг Ерөнхий боловсролын 34 сургуулийн сурагчдын дунд зохион байгуулж, нийт 260 хүүхэд хамрагдсан. Мөн “Өв соёлоо дээдлэе” угийн бичгийн үзэсгэлэн, “Залуу гэр бүл” өдөрлөгт 17 сумын 1200 залуу гэр бүл хамрагдсан. “Шилдэг гэр бүл-2018” арга хэмжээг зохион байгуулж “Үлгэр жишээ гэр бүл”, “Спортлог гэр бүл”, “Тариаланч гэр бүл”, “Өнөр гэр бүл”, “Залуу малчин гэр бүл” 6 номинацаар шалгаруулж, нийт 63 гэр бүл хамрагдсан. “Ирээдүйн эзэд” аяны хүрээнд тус аймгийн 17 сумын 34 сургуулийн 1480 хүүхэд, эцэг эхчүүдийн төлөөллийг хамруулан бүсчилсэн хэлбэрээр 2, “Мини аялал” 5 удаагийн сургалт, 3 удаагийн Экспо өдөрлөгийг зохион байгуулсан.

Залуучуудын нэгдсэн мэдээллийн сан үүсгэх зорилгоор 15-34 насны 35517 залуучуудын судалгааг 17 сумаас авч нэгтгэлээ. Залуучуудад амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх хувь хүний хөгжлийг дэмжих зорилгоор торгон утасны урлал буюу /soutache/ гоёл чимэглэл хийж сурах сургалтыг залуучуудын хөгжлийн төвөөс зохион байгуулж нийт 20 залууг хамруулж, нийгмийн ажилтны сургалтын хэрэгцээ тодорхойлох судалгааг 17 сумаас авч нэгтгэн судалгаанд боловсрол, халамж, эрүүл мэнд, сум баг хорооны нийгмийн ажилтан нийт 99 хүн хамрагдсан. Монгол оронд Хүүхдийн хөдөлгөөн, байгууллага үүсэж хөгжсөний 93 жилийн ойг тохиолдуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд “Би дуулах дуртай” уралдааныг зохион байгуулж нийт 7 хүүхэд оролцож шалгарсан хүүхдүүдийг шагнаж урамшуулсан.

Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг дэлхийн өдрөөр “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэе” аяны хүрээнд сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж, шторк, плакат, гарын авлага тараан нийт 432 эцэг, эх, иргэд хамрагдсан.

Олон Улсын “Хүүхдийн тусламжийн утас”-ны өдрийг тохиолдуулан Ерөнхий боловсролын 34 сургуулийн нийт 2500 хүүхэд тэдний эцэг эхчүүдэд Хүүхдийн тусламжийн 108 утасны мэдээллийг сурталчлан, гарын авлагаар хангаж, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, танин мэдэхүйн чиглэлээр “АХА” тэмцээн зохион байгуулллаа. Аймгийн хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн 5 дуудлагад хариу үйлчилгээ үзүүллээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын 2 удаагийн хурлаар 20 хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэйг тодорхойлж зөвлөгөө өгч, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажлын хэсэг Сайхан суманд ажиллан гишүүд өөр өөрсдийн чиглэлээр хорооны гишүүдэд мэдээлэл өгөхөөс гадна Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдад сургалт зохион байгуулсан.

Ангийн дарга нараар дамжуулан найз нөхдийн холбоог бэхжүүлэх, өсвөр үеийнхний аливаа үйл ажиллагаанд оролцох оролцоог дэмжих, гэмт хэрэгт өртөх, уруу татагдахаас урьдчилан сэргийлэх нөлөөлөх, авьяас чадварыг нь нээн хөгжүүлэх үүднээс “Ангийн дарга нарын зөвлөгөөн”-ийг бүсчилсэн хэлбэрээр 4 удаа зохион байгуулж нийт 180 сурагч сургуулийн нийгмийн ажилтан хамрагдсан.

## **5.Нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:**

2018 оны 05 сарын 20-ны байдлаар 9,7 тэр бум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 05 дугаар сарын 20-ны байдлаар өссөн дүнгээр 9,3 тэр бум төгрөгний орлого төвлөрүүлж 96.34 хувийн биелэлттэй ажиллаж байна. Тэтгэврийн даатгалын сангаас 16114 тэтгэвэр авагчдад 20.2 тэрбум төгрөгийг тэтгэвэрт, Тэтгэмжийн даатгалын сангаас 2276 хүнд 916.39 сая төгрөгийг Хөдөлмөрийн чадвараа түр алдсан, Жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 248 хүнд 395.03 сая төгрөг, Ажилгүйдлийн даатгалын сангаас 162 хүнд 208.79 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгосон.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг энэ сард 195 иргэд, даатгуулагчдад гарган үйлчилж, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор 2018 оны 04 сард нийт 3 удаа хуралдан 244 хүнээс, 13 хүнийг цуцалж, 33 хүн шинээр тогтоолгосон, 198 хүн актаа сунгуулсан байна.

### **Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:**

“Аймгийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн чуулга уулзалт”-ын үеэр 15 сумын 61 аж ахуйн нэгж, иргэд 100 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээгээр өөрийн байгууллагын үйл ажиллагааг үзүүлэн танин мэдэхүй чиглэлээр сурталчилж, 1500 ширхэг гарын авлага материалыг тарааж, 6,5 сая төгрөгийн борлуулалт хийсэн.

“Органик хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журам”-ын төслийн мэдээллийг аймгийн Засаг даргын тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, Стандартчилал хэмжилзүйн хэлтэс, Хэрэглэгчдийн Эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Хоршоологчдийн холбоо, Худалдаа аж үйлдвэрийн танхимын төлөөллийг оролцуулан зохион байгуулж, саналыг авч нэгтгэн Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.

Санхүү эдийн засгийн их сургуультай хамтран “Худалдаа нийтийн хоолны салбарын үйлчилгээний соёл сургалт”-ыг Шаамар, Алтанбулаг, Сүхбаатар сумдын 20 гаруй төлөөллийг оролцуулан зохион байгуулсан. Аймагт бүртгэлтэй нийт 165 хоршооны үйл ажиллагааг үнэлэх ажлыг 2018 оны 3 дугаар сарын 26-наас 5 дугаар сарын 10-ны өдрүүдэд 17 суманд зохион байгуулсан бөгөөд аймгийн хэмжээнд 140 хоршоо үйл ажиллагаагаа явуулж, 25 хоршоо нь цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй татан буулгахаар материал бүрдүүлж өгсөн хоршоо байна. Хоршоодод явуулсан үнэлгээгээр нийт хоршоодын 4,3 хувь нь (6 хоршоо) хөгжиж байгаа, 32,8 хувь нь (46 хоршоо) идэвхжиж байгаа, 62,8 хувь нь (88хоршоо) идэвхгүй гэсэн үнэлгээг тус тус авлаа.

2018 онд нийт 724676 эх мал төллөхөөс 05 дугаар сарын 24-ний байдлаар нийт 457193 мал төллөж үүнээс ингэ 61, гүү 5711, үнээ 27047, эм хонь 249115, эм ямаа 175259 төллөөд байна.Төлийн хорогдол 2999 үүнээс унага 99, тугал 292, хурга 1256, ишиг 1352 хорогдсон дүн мэдээтэй мал төлөлт 63 хувьтай байна. Том малын зүй бус хорогдол нийт 6724 үүнээс тэмээ 2, адуу 440, үхэр 1548, хонь 2475 ямаа 2148 үүнээс хээлтэгч мал нийт 1775 үүнээс гүү 68, үнээ 547, хонь 685, ямаа 475 хорогдож өвчнөөр нийт 278 мал үүнээс адуу 22, үхэр 74, хонь 83, ямаа 99 хорогдсон мэдээтэй байна.

“Мал аж ахуйн тогтвортой хөгжил” сэдэвт Улсын малчдын зөвлөгөөн Улаанбаатар хотод 5-р сарын 17-нд өдөр төрийн ордонд зохион байгуулагдсан бөгөөд зөвлөгөөнд 16 сумын 32 малчны төлөөллийг хамрууллаа.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас тус аймгийн 7 сумын 30.0 мянган га талбайд байгаль орчинд халгүй энгийн механик аргаар тэмцэх арга хэмжээг зохион байгуулахаар батлагдсаны дагуу сумдын Засаг даргатай гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн бөгөөд оготной тэмцэх багаж хэрэгслэл утгагч, цөмлөгч багажийг

хүлээлгэн өгөөд байна. Мөн “Малд үзлэг ангилалт хийж, цөм сүрэг бүрдүүлэх тухай” ажлын удирдамжийн дагуу тус аймгийн Орхон, Ерөө, Хангай үүлдрийн 17800 толгой хонинд үзлэг ангилалт хийх гэрээг ХХААХҮЯ-ын төрийн нарийн бичгийн дарга, Мал эмнэлэг үржлийн газрын дарга нарийн баталсан гэрээний дагуу Орхон, Ерөө, Цагааннуур суманд зохион байгуулж байгаагаас гадна аймгийн Засаг даргын захирамжаар бог, бод малд үзлэг ангилалт хийх ажлыг эхлээд байна.

Мерси корпс ОУБ, Хөгжлийн Шийдэл ТББ, ХХААГ-тай хамтран “Дасан зохицох даван туулах чадвартай орон нутгийн иргэд” хөтөлбөрийн хүрээнд 5-р сарын 1-ээс 4-ний өдрүүдэд 18-35 насны залуучуудын дунд “Шилдэг бизнес санаа шалгаруулах уралдаан”-ыг Сүхбаатар суманд зохион байгуулж, 2-4 хүртэлх гишүүнтэй 6 баг оролцож 1-р байранд Түшиг сумын “Малын тэжээл тарих болон махны үхрийн ферм” сэдэвт бизнес санаа Г.Мөнхтүшиг ахлагчтай баг эзэлж 5,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын дэмжлэгийг авлаа.

Тайлант хугацаанд Мандал, Сүхбаатар, Цагааннуур, Баянгол сумдаас ирсэн мал, амьтны халдварт өвчний сэжиг бүхий дуудлага бүрт шуурхай зөвлөгөө, зөвлөмжийг өгч, Сүхбаатар сумын адууны цус 24, Зүүнбүрэн сумын “Газар Агро” ХХК-ий 59 буханд цусанд буруцеллээ, АХЦӨ, нийлүүлгийн өвчний шинжилгээг тус тус хийж хариуг хүргүүлсэн. Мөн төлөвлгөөт шинжилгээний дагуу Сант, Хүдэр, Орхон сумын 338 хээлтүүлэгч, 127 хээлтэгч малд бруцеллээ өвчний шинжилгээг хийж халдваргүй болохыг тогтоожн хариуг холбогдох газруудад хүргүүлэн ажиллаласан. Мөн шүлхий өвчнийг Улсын хэмжээнд нэгэн зэрэг илрүүлэх эмнэл зүйн болон ийлдэс судлалын тандалтыг Мандал, Баянгол Орхонтуул, Ерөө, Түшиг суманд зохион байгуулж, тус тус бүрт 3 баг 16 малчин өрхөөс цусны тандалт шинжилгээг хийж байна.

### **Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 37 тоот тогтоолоор 7 байгууллагын нийт 109,578,812 төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай, 38 тоот тогтоолоор 3 байгууллагын нийт 28,322,133 төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах тухай, 36 тоот тогтоолоор 5 байгууллагын нийт 116,171,092.04 төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг акталж, данснаас хасах тухай тогтоолуудыг тус тус гаргуулан ажиллалаа.

Аймгийн Засаг даргаас эрх шилжүүлсэн ажлуудыг tender.gov.mn системээр дамжуулан эрхийг нь шилжүүлж, сумдаас ирж буй тодруулгад хариу заавар зөвлөгөөг өгч ажиллаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэн хэрэгжих 12 төсөл арга хэмжээний эрх шилжиж ирсэн бөгөөд тайлант сард 4 төсөл арга хэмжээний тендер зарлагдаж тендерийн материалыг цахимаар хүлээн авч, 2 төсөл арга хэмжээний тендерийн баримт бичиг боловсруулж, 1 төсөл арга хэмжээний зураг төсөв захиалагчаас ирүүлээгй, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэн хэрэгжих 54 төсөл арга хэмжээнээс 35 төсөл арга хэмжээний гэрээ байгуулагдсан, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэн хэрэгжих 27 төсөл арга хэмжээнээс энэ сард 9 төсөл арга хэмжээний тендер зарлагдаж 3 төсөл арга хэмжээ үнэлгээ хийгдэх шатанд, 18 төсөл арга хэмжээний гэрээ байгуулагдсан, Байгаль хамгаалах сангийн зардлаар санхүүжигдэн хэрэгжих 7 төсөл арга хэмжээнээс энэ сард 4 төсөл арга хэмжээний тендер зарлагдаж, 3 төсөл арга хэмжээ үнэлгээ хийгдэх шатанд, 4 төсөл арга хэмжээ гэрээ байгуулагдсан байна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлж эхэлсний 15 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан “Монгол Улсад газар өмчлүүлсний үр дүн, цаашдын зорилт” үндэсний форумд оролцсон. Арга хэмжээний үеэр танилцуулсан газар өмчлөлийн явц орон нутагт хэрхэн хэрэгжиж буй дүнгээс харахад Сэлэнгэ аймаг Улаанбаатар хот, Төв аймгийн дараа орж байна.

Жил бүрийн 5 дугаар сарын эхний 7 хоногийг "Газрын харилцааны ажилтан"-ны өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан 5-р сарын 10-ны өдөр Төрийн албаны ёс зүйн харилцааны Докторант лектор багш н.Болормааг урьж "Харилцаа, хандлага, ухамсарын нөлөө" сэдэвт сургалтыг байгууллагын албан хаагчид, сумдын газрын даамлуудад хийж, Газрын харилцаа үүсч хөгжсөний 64, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлж эхэлсэний 15 жилийн ой, газрын харилцааны ажилтны өдрийг тохиолдуулан байгууллагын албан хаагчдын спортын өмсгөлд монгол бичгээр "Сэлэнгэ" хатгамал хийлгүүлж, байгууллагын нэр, хаягийг бийрэн бичгээр бичүүлэн байршууллаа.

Аймгийн Засаг даргын 2018 оны А/82 тоот захирамжаар Сэлэнгэ аймгийн газрын төлбөрийн орлогын 2018 оны төлөвлөгөөний биелэлтийг хангах, газар эзэмшигч ашиглагч иргэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших ашиглах гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулан ажиллах талаар 17 сумдад чиглэл хүргүүлэн ажилласан. Тухайн ажлын хүрээнд Мандал сумын 82 иргэн аж ахуйн нэгж байгууллагын 503 нэгж талбар, Жавхлант сумын 16 иргэн аж ахуйн нэгж байгууллагын 76 нэгж талбар, Сайхан сумын 148 иргэн аж ахуйн нэгж байгууллагын 148 нэгж талбар, Хүдэр сумын 6 иргэн аж ахуйн нэгжийн 24 нэгж талбар, Цагааннуур сумын 8 аж ахуйн нэгжийн 160 нэгж талбар, Сүхбаатар сумын 24 төрийн байгууллагын 80 нэгж талбар, 80 иргэн аж ахуйн нэгжийн 95 нэгж талбарын газар эзэмших гэрээг дүгнэж аймгийн хэмжээнд нийт 360 газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 1080 нэгж талбарын газар эзэмших, ашиглах гэрээг дүгнэж газрын орлого 2018.05.23-ны байдлаар 150,685,828 сая төг буюу ногдуулалтын гүйцэтгэлээр 100% гүйцэтгэлтэй явж байна.

### **Долоо. Байгаль орчин, аялал жуулчлалын хүрээнд**

2018 оны 5-р дугаар сарын 04, 08, 15-ны өдрүүдэд нийт нутгаар 0,0-9,0 мм хур тунадас орж, ихэнх хугацаанд салхи баруун болон баруунаас 4-9 м/сек байв. 14, 15-нд нийт нутгаар салхи баруун хойноос 8-13 м/сек хүрч шороон шуурга шуурсан. 5 дугаар сарын 1-р арав хоногт шөнөдөө 3-8 градус хүйтэн, өдөртөө 15-20 градус дулаан, 2-р арав хоногийн дунд үеэр дулаарч шөнөдөө 5-10 градус өдөртөө 25-30 градус дулаан, бусад хугацаанд шөнөдөө 2 градус хүйтнээс 3 градус дулаан, өдөртөө 15-20 градус дулаан байлаа.

"Ойн үрийн генетик нөөцийн тухай" төслийн багтай хамтран "Үр түүх тухай" сургалтыг зохион байгуулж, Ойн анги, ойн мэргэжлийн байгууллага, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлийн 20 гаруй хүмүүс хамрагдаж, үр түүх талбайг сонгох, үрийн ургацын балл тогтоох тухай, үрийг тээвэрлэх, хадгалах тухай, мод сөөгний үрийн чанарын шинжилгээ хийх тухай зэрэг сэдвүүдээр танхимын сургалт хийлээ. Мөн ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх тухай сургалтыг Алтанбулаг, Хүдэр, Мандал, Жавхлант сумд, Ерөө сумын Бугант тосгонд хийж, 200 гаруй хүн хамрагдсан.

Байгаль орчны эсрэг гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Шаамар сумын 4 замын хяналтын постоос гадна Жавхлант сумын шарын голын гүүрний орчимд 45 хоногийн хугацаанд хяналтын пост түр ажиллуулж байна.

### **Найм.Сум орон нутгийн талаар**

#### **Алтанбулаг сум:**

Төрийн албан хаагчдын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулж, бие бялдрыг чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор спортын 5 төрөлт тэмцээнийг 05 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгуулж, төр, төсвийн байгууллагын 7 баг өрсөлдөж, багийн дүнгээр ЕБС тэргүүн байр, сумын Засаг даргын Тамгын газар дэд байр, Бүргэдэй хилийн застав гутгаар байрыг тус тус эзэлж амжилттай оролцлоо.



бялдрын хөгжил, түвшин тогтоох сорилыг сумын Засаг даргын Тамгын газар, ЕБСургууль, 25-р цэцэрлэг, ЭМТ-ийн нийт ажилтан, албан хаагчид болон Бургалтай 2 дугаар багийн иргэдээс авч, нийт 540 хүн хамрагдлаа.

“Бид Сэлэнгийн үр сад-2018” аймгийн хүүхдийн урлагийн их наадамд нийт 16 хүний бүрэлдэхүүнтэй амжилттай оролцож, морин хуурийн аялгуу хамтлаг 1-р байр алтан медаль, 12а ангийн сурагч Ц.Энхманлай мөнгөн медаль, 7а ангийн сурагч М.Баярсүрэн мөнгөн медаль хүртсэн амжилтыг үзүүлээ. Мөн МУГЖ Д.Лувсандашийн нэрэмжит хүүхдийн бүжгийн их наадмаас тус сургуулийн Цоглог-3 хамтлаг хүрэл медаль, 5а ангийн сурагч Б.Хэрлэн мөнгөн медаль, “Сэлэнгээр жигүүрлэсэн бидний эгшиг” аймгийн аварга шалгаруулах хөгжмийн уралдаанд нийт 12 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, 10а ангийн сурагч Б.Ариунцэцэг Ятга хөгжмөөр 3-р байр хүрэл медаль, 9б ангийн сурагч М.Баяржаргал Морин хуур хөгжмөөр 3-р байр хүрэл медаль хүрсэн амжилтыг тус тус үзүүлээ. Энэ сарын 02-ны өдөр Д.Мягмарын нэрэмжит ЕБС-ийн 1-р ангийн сурагчдын “Үсэглэлийн баяр” болж зохион байгуулж, ““Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг тохиолдуулан 5-р сарын 07-ны өдөр ЕБС-ийн 6-р ангийн сурагчдын дунд “Зөв цэвэр бичигтэн” уралдаан зохион явууллаа.

### **Баянгол сум:**

Төр, төсвийн байгууллагын албан хаагчдыг чадавхижуулах зорилгоор Удирдлагын академийн багш нартай хамтран “Төрийн албан хаагчийн манлайлал”, “Багаар ажиллах чадвар”, “Байгууллагын соёл үнэт зүйлс”, “Цагийн менежмент”, “Удирдлага зохион байгуулалт”, Албан хэрэг хөтлөлт-ийн чиглэлээр сургалт хийж, сумын төрийн албан хаагчдын хамрууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар зохион байгуулдаг “Бүх нийтийн мод тарих үндэсний өдөр”-өөр сумын Засаг даргын Тамгын газрын хамт олон 50 улиас, 300 шар хуас тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүллээ.

Сумын хэмжээнд 4310 га-д үр тариа, 57,1 га-д төмс, 49,9 га-д хүнсний ногоо тариалаад байна. Мал төллөлтийн мэдээгээр нийт 42392 толгой мал төллөж, төл бойжилт 99,5 хувьтай, 629 толгойтом мал, 228 толгой төл хорогдсон байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг технологит хугацаанд нь зохион байгуулж, боом өвчний тарилгыг 19840 толгой малд, шөвөг яр өвчний тарилгыг 4560 толгой малд хийгээд байна. Мөн зөөврийн мал угаалгын ваннанд туршилтаар мал угаах ажлыг хийлээ.

Хаврын хуурайшилтын нөхцөл байдалтай уялдуулан ой хээрийн түймэр, байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг тогтмодл зохион байгуулж, 81 иргэн, 3 аж ахуйн нэгжид зөвлөгөө, сэрэмжлүүлэг өглөө.

Тайлант сард “Гэр бүлийн өдөр” арга хэмжээг тэмдэглэж, сумынхаа нийт гэр бүлүүдэд зориулан сумын соёлын төвөөс “Дуун цацал” концертыг хүргэсэн. Мөн аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан “Нэг хүүхэд-нэг байгууллага” аяныг сумын төр төсвийн байгууллагуудын хэмжээнд зохион байгуулж, Баян багийн зорилтот бүлгийн өрхөд хувцас, эд материалын туслалцаа үзүүлсэн.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг татвар төлөгчдийн өдрийн хүрээнд “Эх оронч үзэл татвар төлөхөөс эхэлнэ” гар зургийн уралдааныг зохион байгуулж, аймгийн Засаг даргын нэрэмжит төрийн албан хаагчдын спортын 5 төрөлтийн тэмцээнийг зохион байгуулсан.

### **Сайхан сум:**

Сумын хэмжээнд 2018 оны хаврын тариалалтын ажил 5-р сарын 6-аас эхэлсэн бөгөөд 5-р сарын 21-ний байдлаар улаан буудай 4250 га, рапс 2360 га, гурвалжин будаа 758 га, төмс 165 га, лууван 50 га, манжин 50 га, сонгино 30 га-д тус тус тариалаад байна. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн газраас хэрэгжүүлж буй SECIM



сургалтанд Номгон тосгоны 2 бүлгийн ногоочид хамрагдаж, Эко нутгийн шим, Хүлэмжийн бүлгүүдэд эрт ургацын лууван болон өргөст хэмхийн үрийг өгсөн.

Төл мал болон том малын зүй бус хорогдлын мэдээг 7 хоног бүр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэн ажилласан. 5-р сарын 23-ны байдлаар мал төллөлт сумын хэмжээнд 32884 , том малын хорогдол 917, төлийн хорогдол 293 байна.

МУ-ын Засгийн газар, ХХААХҮЯам, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн газар, Швейцарын Хөгжлийн агентлагаас зохион байгуулсан “Мал аж ахуйн тогтвортой хөгжил-2018” малчдын Улсын зөвлөгөөнд малчны төлөөллийг оролцуулсан. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин боомын тарилга үхэрт 10000, шөвөг яр тарилгыг 10000 төлд, туулгалтанд 22,0 бог, боловсруулалтанд бод 10000, Эрүүл мэндийн үзлэг шэнжилгээнд бод 10000, бог 49000 мал шинжилгээнд хамруулж, ариутгал халдваргүйжүүлэлтэнд нийт 19000 м<sup>2</sup> талбай бүхий 39 өвөлжөө хашаа хороог хамруулж, 612 малын сэгийг устгасан.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Мод тарих үндэсний өдөр” зарлах тухай 63-р зарлиг, 2013 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 178-р зарлигийн дагуу 5-р сарын 11-14-ны өдрүүдэд 15 аж ахуйн нэгж, байгууллагын 151 иргэн, нийт 2769 ширхэг бут сөөг, мод суулгац, тарьж суулгаж, мөн 45м<sup>2</sup> талбайд цэцгийн мандал, 40м<sup>2</sup> талбайд зүлэгжүүлэлтийн ажил тустус хийлээ.

Татвар төлөгчдийн өдрийг тохиолдуулан 5-р сарын 8-ны өдөр ЕБС-ийн 9-12 дугаар ангийн 56 сурагчдын дунд татварын багц хуулиудыг сурталчлах сургалтыг аймгийн Татварын хэлтсийн улсын байцаагчид хийж, ЭССЭ бичлэгийн уралдаан зохион байгуулж, Номгон тосгоны өрийн үлдэгдэлтэй аж ахуйн нэгж, байгууллагад мэдээлэл хийж, 19 аж ахуйн нэгж байгууллага 975376695,7 төгрөгийн өрийг барагдуулсан байна.

“Дэлхийн гэр бүлийн өдөр”-ийг угтан “Гэрэлт ирээдүйдээ итгэл бэлэглэе” уриан дор төрийн албан хаагч нарын дунд урлагийн наадам зохион байгуулагдаж, Хөтөл ЕБС, 24-р цэцэрлэг, сум дундын Цагдаагийн хэлтэс эхний 3 байрт шалгарлаа.

Хөтөл Соёлын ордон нь “Бүжгийн ертөнц” хүүхдийн урлагийн наадмыг Орхон бүсийн хэмжээнд уламжлал болгон 14 дэх жилдээ амжилттай зохион байгууллаа. Аймаг, сумын засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, Хүүхэд хөгжил, хамгаалал үндэсний хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан тус наадамд нийт давхардсан тоогоор 1200 хүүхэд хамрагдаж авьяас билгээ сорин өрсөлдсөн.

“Мэргэжил сонголт”-2018 зөвлөгөөн 05-р сарын 5-ны өдөр Соёлын ордонд зохион байгуулагдаж, 12-р ангиа төгсөж буй төгсөгчдөд зориулсан мэргэжлээ хэрхэн зөв сонгох вэ? юунд анхаарах талаар олон талын ач холбогдолтой боллоо.

### **Ерөө сум:**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийн дагуу “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн арга хэмжээг 5-р сарын 14-нд зохион байгуулж, 14 аж ахуйн нэгж, байгууллага нарс, улиас, агч, голт бор зэрэг 4 нэр төрлийн 204 ширхэг модыг шинээр болон нөхөн тарилтаар суулгалаа. Арга хэмжээний нээлтэнд ЗДТГазар, ЕБСургууль, Нарлаг цэцэрлэг, соёлын төв, цаг уур, эрүүл мэндийн төвийн албан хаагчдаас гадна, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК, “БТЕГ” ХХК, Тавин ус өртөө болон уламжлалт гэр ахуйн модон эдлэл хийдэг иргэд хамрагдсан бөгөөд “БТЕГ” ХХК нь /Улиас/ 90ш -ийг хандивлаж, Бугант минж ХХК, Мөнх төгөл ойн нөхөрлөлүүд 5 нэр төрлийн 400 ширхэг тарьц, суулгацын үзэсгэлэн гаргаж оролцлоо.

Хугацаат цэргийн албаны 2018- оны 1-р ээлжийн цэрэг татлагыг Ерөө суманд энэ сарын 4, 5-ны өдрүүдэд зохион байгуулж, Ерөө бүсийн Ерөө, Бугант тосгон, Хүдэр, Жавхлант сумдын 18-25 насны нийт 204 залуучууд эрүүл мэндийн үзлэгт орсноос Ерөө сумын 2-р багийн 4, Бугант тосгоны 2, Жавхлант сумын 4, Хүдэр сумын залуу тэнцэж цэргийн албанд мордлоо.

Хууль эрх зүй сургалт сурталчилгааны төлөвлөгөөний дагуу аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хүн амын оорлогын албан татварын болон Зөрчлийн тухай хууль, Малын эрүүл мэндийн тухай хууль, генетикийн нөөцийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох хөнгөлөлт, тусламжууд, магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилал, 2018 онд протез, ортопед болон тусгай хэрэгсэл олгох эрх бүхий аж ахуйн нэгжүүд, эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ, тэтгэврийн дэвтэрт хугацааны сунгалт, баяжилтыг хийлгэх, иргэний бичиг баримтын хугацааны сунгалтын тухай мэдээллийг тус тус хийж, хог хаягдлын тухай хуулиар 55, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх нь сэдвээр 48 гарын авлага, иргэний бүртгэлд бүртгүүлэхэд бүрдүүлэх материалын жагсаалт, өргөдлийн загвараар бяцхан ном, тараах материал 250 ширхэгийг хийж тараасан.

Сумын "ЕРӨӨ СУМ ВЭБ САЙТ"-д 5-р сард 63 мэдээ мэдээлэл оруулж, давхардсан тоогоор 1699 иргэн хандсан байна.

2018 онд сумын хэмжээнд нийт 15000 га талбайд үр тариа тариалах төлөвлөгөөтэйгөөс 5-р сарын 25-ны байдлаар тариалалтын явц 49,8%-тай байна.

### **Жавхлант сум:**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурал хуралдаж сум хөгжүүлэх сангийн зээл олгох төсөл хүлээж авах тов, "Суралцагч байгууллага-Төрийн албаны манлайлал", "Залууст боломж", "Бид Жавхлантын ирээдүй хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах", "Жаргалтай гэр бүл", "Эрүүл Жавхлантчууд", "Эрчимжсэн үхрийн аж ахуй", "Жавхлант төмс, хүнсний ногоо", "Өрхийн туслах аж ахуйг хөгжүүлэх", "Нэг сум-нэг үйлдвэрлэл үйлчилгээ" сумын дэд хөтөлбөрүүдийг баталлаа.

Ерөө бүсийн төрийн албан хаагчдын урлаг спортын арга хэмжээ амжилттай зохион байгуулагдаж урлагийн төрөлд Жавхлант сумын ЗДТГазар 1-р байр, нийлбэр дүнгээр Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн алба 1-р байр шилжин явах цомын эзэн болж Жавхлант сумын Засаг даргын Тамгын газар 2-р байр эзэлсэн амжилт үзүүллээ.

2018 оны нэгдүгээр ээлжийн цэргийн жинхэнэ албаны татлагад 1992 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2000 оны 05 дугаар сарын 09-ний хооронд төрсөн 2-р зэргийн цэргийн бэлтгэл үүрэгтэн 5 залуу тэнцэж цэргийн албанд мордлоо.

Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилтын хүрээнд Шүүхийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн дунд шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх үүрэг сэдвээр сургалт, "Бэлчээрийн доройтол тулгамдаж буй асуудал" сургалт, Эрүүл мал эрсдэлгүй бүтээгдэхүүн сургалт, "Secim" төслөөс Жавхлант хөгжлийн төлөө ногоочдын бүлэгт сургалт зохион байгуулан "NAVAL F1" сортын лууван, "Elisa F1" сортын өргөст хэмхийн үрийн танилцуулга хийж, нийт давхардсан тоогоор 781 иргэн төрийн албан хаагч нар хамрагдлаа.

Сумын Засаг даргын баталсан "Хяналт" нэгдсэн арга хэмжээний удирдамжийн дагуу Бумбат 1-р багийн Хүйтний гол дагуух нийт 63 өрх айлд БОХ-ын улсын байцаагч, Татварын байцаагч, Газрын даамал, Нийгмийн даатгалын байцаагч нар СОК болон сумын удирдлагуудын утасны жагсаалт, гарын авлага боршур, түймрийн мэдэгдэл, 2,3,4-р сарын Жавхлантын мэдээ сонин болон цаг үеийн мэдээлэлийг иргэдэд хүргэлээ.

Авто тээврийн улсын үзлэг энэ сарын 9,10-нд зохион байгуулагдаж нийт 226 авто машин хамрагдсанаас чиргүүл 2, мотоцикл 15 хамрагдлаа.

5-р сард шинээр жирэмсэн эхийн тэтгэмжид 5 иргэн, цалинтай ээж хөтөлбөрт 5 иргэн, амралт сувилалд 1 ахмад, рашаан сувилалд 5 ахмад, шүдний хөнгөлөлт 3 ахмад, групп 3 иргэн, байнгын асаргаа 2 иргэн тус тус хамрагдлаа.

"Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах төсөлд сумын зорилтот бүлгийн иргэдийн дундаас Бумбат 1-р багийн иргэн Б.Батаа хамрагдлаа. Тус иргэнд 1000000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүллээ.

“Бид Сэлэнгийн үр сад” урлагийн их наадмаас 12а ангийн сурагч О.Содонцэцэг ардын дууны төрлөөр хүрэл медаль, эстрад дууны төрлөөр мөнгөн медаль тус тус хүртлээ.

“Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан “Спортлог гэр бүл” шалгаруулах гар бөмбөгийн тэмцээнийг “Хүүхэд гэр бүлтэйгээ байхдаа жаргалтай” хүүхэд эцэг эхийн эерэг харилцааг дэмжих зорилгоор амжилттай зохион байгууллаа.

Тухайн сард  $\dot{\epsilon}\epsilon\dot{\circ}$   $\dot{\zeta}\dot{\epsilon}\dot{y}\dot{a}$   $\dot{\beta}\dot{\epsilon}\dot{\epsilon}\dot{a}\dot{a}\dot{n}\dot{y}\dot{u}$   $\dot{y}\dot{u}$  сурьдчилан сэргийлэх –380, амбулаторийн  $\dot{\zeta}\dot{\epsilon}\dot{y}\dot{a}$  35, идэвхитэй хяналт -37, гэрийн идэвхитэй үзлэг- 65,больницод 14 хүнийг хэвтүүлэн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж зөвөлгөө өгч ажиллалаа. Олон улсын сувилагч нарын өдрийг тохиолдуулан “Судлаач сувилагч 2018” онол практикийн хурал, гардан үйлдэл ур чадварын уралдааныг Эрүүл мэндийн газраас Сэлэнгэ аймгийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулсан бөгөөд энэхүү арга хэмжээнд эрүүл мэндийн төвийг төлөөлж сувилагч Ж.Долгормаа “Жирэмсэн эмэгтэйчүүдийн жирэмсний хяналтын талаарх мэдлэгийг судалсан дүн” сэдэвт судалгааны ажлаар амжилттай оролцож 3-р байр эзэллээ. Эрүүл мэндийн төвийн яаралтай тусламжийн нэгж болон төрөх тасгийг стандартын дагуу ажиллуулах зорилгоор яаралтай тусламжийн шүүгээ бүхий тэргэнцэр, хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат, салиа соруулах аппарат зэрэг тоног төхөөрөмжөөр хангагдлаа.

Мандал суманд зохион байгуулагдсанномын санчдын ур чадварын уралдаан, “Сэлэнгэ-өв соёл” үзэсгэлэн өдөрлөгт номын санч, орон нутаг судлах танхимын ажилтан нар амжилттай оролцож тус Соёлын төв нь дэд байранд шалгарсан амжилт үзүүллээ.

"Эрүүл мал-Эрсдэлгүй бүтээгдэхүүн" сарын аяны хүрээнд "Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль", "Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээ", "Махны чанар аюулгүй байдал" сэдэвт сургалтыг малчид, мал бүхий иргэд болон багийн Засаг дарга нар, мал эмнэлгүүдийг оролцуулан зохион байгуулж, зөвлөмж зөвлөгөө өглөө.

2018 онд 6500 га талбайд тариалалт хийгдэхээс улаанбуудай 4500 га, төмс 36 га, хүнсний ногоо 68 га талбайд тариалалт хийгдээд байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны "Мод тарих үндэсний өдөр зарлах тухай" 63 дугаар зарлиг, Байгаль хамгаалах сарын аяны хүрээнд төр төсвийн 5-н байгууллага, ХААН банк, ахмадын хороо, иргэд хашаандаа 7 нэр төрлийн 150 ширхэг гоёлын мод, 6-н нэр төрлийн 105 ш жимсний мод нийт 255 ш мод бут, цэцэг зүлэг тариж суулган ногоон орчинг бий болгоод байна.

Аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж бэлчээрийн талбайн хөрсийг хамгаалах, цөлжилттэй тэмцэх зорилгоор "Үлийн цагаан огтоно" устгах ажлыг зохион байгуулан ажиллаж Баян харын уулын өврөөс сумын төвийн чиглэлд, ШТС-ын ар тал, Хогийн цэгийн ар, замын урд болон ар хэсэг, төв замаас Шарын голын тосгон руу салдаг зам дагуух нийт 48 га бэлчээрийн талбай хамрагдав. Тус ажлыг сумын хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй 8 иргэн, 2 дүйцүүлэх цэрэг хийж гүйцэтгэв.

### **Зүүнбүрэн сүм:**

Тайлант сард сумын Засаг даргын 11 захирамжийг боловсруулан гаргаж хэрэгжилтийн ханган ажиллалаа. Үүнд: Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай, орон нутгийн байгууллагын 2018 оны төсвийн сар, улирлын хуваарьт тодотгол оруулан батлах тухай, татвар төлөгчдийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай, Засаг даргын Тамгын газарт универсаль трактор нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай, зам засвар, тэмдэг тэмдэглэгээ хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай, “Иргэн бүр тусалъя” хандивын сайн үйлсийн аяныг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай, хөрөнгө гаргах тухай, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг явуулах ажлын хэсэг байгуулах тухай, мал эмнэлгийн урьдчилан

сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай, бог малд ангилалт, бүртгэл ээмэгжүүлэлт явуулах ажлын хэсэг байгуулах тухай гэх мэт.

“Органик хүнсний тухай хууль”-ийг дагаж мөрдөж журмыг Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран хөдөө аж ахуйн анхан шатны үйлдвэрлэл эрхлэгч, малчид, тариаланчдын дунд зохион байгуулж 5 аж ахуйн нэгж, 135 иргэнийг хамруулж гарын авлагаар ханган ажилласнаас гадна зорилтод 15 өрхийн гишүүд болон хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй өрхийн гишүүдэд албан бус боловсролын төвтэй хамтран “Насан туршийн боловсролын зорилго, зорилт”, “Тогтвортой хөгжлийн боловсрол” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Эрүүл мэндийн төв нь 30 иргэнийг хэвтүүлэн эмчилж, амбулаториор 412 иргэнд үзлэг хийснээс өвчний учир 340, урьдчилан сэргийлэх үзлэгээр 19, диспансерийн хяналтаар 21, гэрийн идэвхитэй эргэлтээр 30, дуудлагаар 22 иргэнд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүллээ. Ээлжит товлотт вакцинд 1 хүртэлх насны хүүхдийг 100 хамрууллаа.

Зүүнбүрэн сумаас төрөн гарсан Монгол Улсын гавъяат жүжигчин Б.Батбаатарыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулсан. Мөн Сэлэнгэ бүсийн ахмадын “Дуулах өдөр-дуун цэнгүүн” –д амжилттай оролцон ардын авьяастан болон соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч П.Хишигжав, Ц.Сарантуяа нар ахмадын урлагийн их наадамд оролцох эрхийн эзэд боллоо. “Хоймор нутгийн хийморлог Бүрэнчүүд” байгууллага сурталчлах өдөрлөгийн хүрээнд Засаг даргын Тамгын газар, Ахмадуудын урлагийн тоглолт зохион байгуулагдаж 230 гаруй иргэнд урлагийн тоглолтоор үйлчиллээ.

2017-2018 оны хичээлийн жилд 1 дүгээр ангид элсэн орсон 63 сурагчид “Эрдмийн баяр” –аа тэмдэглэн аваргуудаа тодруулан шагнаж урамшууллаа. Аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгуулагдсан “Бид Сэлэнгийн үр сад” дууны тэмцээнээс 3б ангийн сурагч Анхцэцэг мөнгө, 8 дугаар ангийн сурагч Баясгалан алтан медаль, Улсын аварга шалгаруулах жудо бөхийн тэмцээнээс 5 дугаар ангийн сурагч Н.Саранцогт хүрэл медаль тус тус хүртлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 тоот зарлигийн хэрэгжилтийг ханган сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 6700 ширхэг жимс, жимсгэнэ, хайлаас, шилмүүс, навчит мод зэргийг тариаллаа.

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээнд Энхбүрэн сүрэг, Оюутсүрэг МЭҮН-д 11300 толгой бог малын төлийг 100 хувь хамрууллаа.

“Даван туулах дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” хөтөлбөрийн хүрээнд Энхбүрэн сүрэг, Оюутсүрэг мал эмнэлгүүдэд тус бүр 8 сая төгрөгний өртөг бүхий 1000 богийн багтаамжтай 40 ширхэг зөөврийн хашааг Олон улсын MERCY-CORPS байгууллагаас олголоо.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжиж буй Ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрт 2 иргэн хамрагдаж 5,0 сая, бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах хөтөлбөрт 1 өрхийг хамруулж эргэн төлөгдөхгүй 1.0 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг олголоо.

Галын аюулд өртөж орон гэргүй болсон өрхүүдэд сэтгэл санааны болон эд материалын дэмжлэг үзүүлэх зорилгоор “Иргэн бүр тусалъя” аяныг зохион байгуулж байна. Энэхүү хандивын аяныг эхлүүлж нийт төрийн албан хаагчид 1 өдрийн цалин, Санчир буудай ХХК 300,000, Иж бүрэн ХХК 50,000 төгрөгийн тусламж болон Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат 4 өрхөд өргөө цагаан гэр хандивлалаа.

Тээврийн хэрэгслийн хяналтын улсын үзлэгийн 2018 оны 05 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулж нийт 334 тээврийн хэрэгсэлийг хамрууллаа.

Улсын төвлөрсөн төсөвт 4.190.000 төгрөг төвлөрүүлэхээс 29.984.800 төгрөг төвлөрүүлж 715.6%, аймгийн төвлөрсөн төсөвт 53.175.000 төгрөг төвлөрүүлэхээс 30.389.00 төгрөг төвлөрүүлж 57.1%, сумын төвлөрсөн төсөвт 10336.000 төгрөг төвлөрүүлэхээс 11858.922 төгрөг төвлөрүүлж 114 хувийн гүйцэтгэлтэй байна.

## **Мандал сум:**

2018 оны хаврын 1-р ээлжийн цэрэг татлага 4-р сарын 25, 26, 27-ны өдрүүдэд сумын Спортын ордонд зохион байгуулагдаж, 2 дугаар зэргийн цэргийн бэлтгэл үүрэгтэн 450 залуучуудыг эрүүл мэндийн үзлэгт хамрууллаа.

Сумын 8 багийн хэсгийн ахлагч нарын сургалт зөвлөгөөнийг Иргэний танхимд 5-р сарын 8-ны өдөр зохион байгуулж, баг, хэсгийн ахлагч, СӨХ, айл өрхүүдийн хоорондын уялдаа холбоог сайжруулах, хог хаягдлын нэгдсэн системтэй болох тухай асуудлыг хэлэлцэж, Зөрчлийн тухай, "Хог хаягдлын хуулийн тухай" хууль, сумын хог хаягдлын өнөөгийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээ, "Ариутгал халдваргүйтгэлийг хэрхэн зөв бэлтгэх тухай" зэрэг сэдвүүдээр мэдээлэл өгсөн.

"Монголын хүний нөөцийн хөгжлийн үндэс" зөвлөлийг үүсгэн байгуулагч, Олон улсын мэргэжлийн хөгжлийн институтын ерөнхий захирал Б.Батгэрэлийн "Хүн та өөрөө амжилтын үндэс" сэдэвт лекц, Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан Эрдэнэ зуу хийдийн хамба лам Х.Баасансүрэнгийн "Хайрлаарай" сэдэвт лекцийг "Мөнгөн хараа" дуу бүжгийн чуулгад зохион байгуулан 600 гаруй иргэнийг хамрууллаа.

Сумын Төрийн албан хаагчдын спортын 5-н төрөлт тэмцээнийг 5-р сарын 19-20-ны өдрүүдэд зохион байгуулж, 16 багийн 672 тамирчин хурд хүч авхаалж самбаагаа сорин оролцлоо.

Мэргэжил сонголтын аяныг сумын хэмжээнд Сургууль ба мэргэжил сонголт, мэргэжил суртчилах "Мэргэжил бүхэн сайхан", "Мэргэжил сонголт ба мэргэжлийн экспо" гэсэн 3 үе шаттайгаар зохион байгуулж, Зүүнхараа ПТК нь ЕБС-дад болон залууст мэргэжил суртчилах 7 хоногийн аяныг өрнүүлж, ойжуулагч мэргэжлийн 8 нэр төрлийн 56 ш суралцагчийн бүтээл, багшийн 1 бүтээл нийт 57 бүтээл үзэсгэлэнг гаргасан. Мөн ЕБС-ийг 2018 онд төгсөж буй нийт 344 сурагчдад сургалт мэдээлэл өглөө.

МУ-ын 29 дахь Ерөнхий сайд, УИХ-ын гишүүн Жаргалтулгын Эрдэнэбатын санаачилгаар Мандал сумын Нэгдсэн эмнэлэг, Засаг даргын Тамгын газар Халдвар судлалын үндэсний төвийн хамтарсан баг "Хавдрын эрт илрүүлгийн үзлэг оношлогоо"-г 5-р сарын 21-ээс 24-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Мандал сумын Улаан загалмайн хороотой хамтран "Инээмсэглэ" нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, иргэд УЗХ-ны үйл ажиллагаатай танилцаж, сайн дурын идэвхтэн сурагчид урлагийн тоглолт сонирхуулж, "Нигүүлсэл" мөнгөн медаль, "Тусч хүүхэд" алтан медаль, "Тэргүүний сайн дурын идэвхтэн" медалийг хүмүүнлэг, энэрэнгүй сурагч болон сайн дурын идэвхтнүүдэд гардуулж, зорилтот бүлгийн 11 өрхөд, ЕБ-ын 3-р сургуулийн 8в ангийн сурагчид хүмүүнлэгийн тусламж үзүүллээ.

Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан Зүүнхараа Хүүхдийн Ордон, ДЗМОУБ ЗХОНХХ-тэй хамтран "Гэр бүлийн өдөрлөг"-ийг тэмдэглэн өнгөрүүлж, ЕБС-уудын ахлах ангийн сурагчдын дунд "Миний гэр бүлийн нэг өдөр" сэдэвт гар зургийн уралдаан, ахлах ангийн сурагчдын дунд эссэ бичлэгийн уралдааныг зохион байгуулж, өргөмжлөл үнэ бүхий зүйлээр шагнаж урамшууллаа. Тус арга хэмжээний үеэр "Өөрчлөлтийг өөрөөсөө ТББ"-н тэргүүн н.Даваасамбуу "Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга" сэдэвт лекцийг уншиж, оюуны хөрөнгө оруулалт хийлээ. Мөн өөртөө өөрчлөлт хийж, архинаас гарч гэр бүлээ сайн авч яваа 5 хүүхдийн ээж зорилтот бүлгийн өрхийн гишүүн М.Урангоо сэтгэлийн яриа өрнүүлэн, архины хамааралтай иргэдийг уриалж, үлгэр дуурайлал болж байгааг урамшуулан ДЗМОУБ ЗХОНХХ-н хамт олноос 169 литрийн багтаамжтай хөргөгчөөр шагнаж урамшуулсан.

Сумын төв доторх 1.6 км хатуу хучилттай асфальтан зам барих, гүний худаг, усан сан барьж, ухаалаг худгийн систем нэвтрүүлэх, Түнхэл тосгоны довын хэсэгт 60м урттай автомашины гүүр барих, Агаарын чанарын харуулын байр барих, халаалт, цэвэр бохир усны шугамын угсралтын ажил, Мөнгөн хараа чуулгын дижитал пульт худалдан авах, Хот тохижуулах газарт хог тээврийн 3 ширхэг автомашин худалдан авах, Хүүхэд залуучуудын соёл спортын цогцолбор төвийн А блокны нэмэлт

саравчны ажил, Мандал сум дахь сум дундын цагдаагийн хэлтэст төрийн үйлчилгээний автомашин худалдан авах, ЗДТГ-т төрийн үйлчилгээний автомашин худалдан авах, сумын ЗДТГ-ын гадна пасад, дээврийг засварлах, “Цант Орхон” ОНӨААТҮГ-ын албаны хэрэгцээнд суудлын автомашин худалдан авах зэрэг 11 төрлийн ажлыг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn сайтад байршуулж, 2 ажлын нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 9 ажлыг тендер шалгаруулалтын онцгой журмаар тус тус зарлаж, тендер шалгаруулалтын ажлыг эхлүүлээд байна.

Сумын нутаг дэвсгэрт ой хээрийн түймэр гарч болох байгалийн нөхцөл бүрдсэн тул мод бэлтгэл, тээвэрлэлт, аялал зугаалга, ойн дагалт баялаг ашиглах, ан хийх, загас барих, бугын эвэр түүх зэрэг үйл ажиллагааг 4-р сарын 01-ний өдрөөс 6-р сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд хариуцлагатай жижүүрийгтомилон ажиллуулж байна.

Мал эмнэлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ВИ-ТИ-НЕТ төрийн бус байгууллагатай хамтран малын эмийн хэрэглээ, малын өвчний тухай орон нутгийн малчдад сургалт хийж, 26 малчин хамрагдлаа. Мал эмнэлэгийн албанаас ирүүлсэн вакцин тарилгыг сумын нутаг дэвсгэрт хийж гүйцэтгэхээр мал эмнэлэгийн 5 нэгжтэй хамтран Боом, шөвөг яр, гахайн мялзан, сахуу өвнөөс урьдчилан сэргийлэх тарилгын ажлыг эхлүүлээд байна.

Сумын дүнгээр улаан буудай 5300 га, төмс 420 га, хүнсний ногоо 280 га талбайд тариалагдаж, тариалалтын явц 73 хувьтай байна.

### **Орхонтуул сум:**

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан сумын Засаг даргын Тамгын газарт Чанарын удирдлагын менежмент 9001 стандартыг нэвтрүүлж төрийн үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэх зорилгоор Монголын чанарын удирдлагын зөвлөхүүдийн холбоотой гэрээ байгуулан ажиллаж байна. Чанарын стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд Засаг даргын Тамгын газарт хөтөлгөдөж байгаа бичиг баримтуудыг нэг загвартай болгох болон бичиг баримтаа эмх цэгцтэй байлгах үүднээс хавтасжуулах, ажлын бүтээмжээ байнга сайжруулах “5s” сургалтыг зохион байгууллаа. Иргэдэд төрийн үйлчилгээ авах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор өрөөний бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт оруулж иргэд хамгийн их үйлчилгээ авдаг Нэг цонхны үйлчилгээг 1 давхарт байрлууллаа.

Тус суманд 2016 онд баригдаж ашиглалтанд хүлээн авсан Хүүхэд хөгжлийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулахаар 4,5 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авах асуудлыг шийдвэрлэж, орон тоо цалин болон эрхлэгч, багшийн ажлын хэрэгцээнд 2 ширхэг компьютер олголоо.

Сумын Архивт хадгалах хугацаа дууссан болон татан буугдсан байгууллагуудын 1998-2010 оны нийт 138 ширхэг баримтад эрдэм шинжилгээ техник боловсруулалт хийж аймгийн Төрийн архивт хүлээлгэж өгөх ажлыг тайлант хугацаанд зохион байгууллаа.

Эхний 5 сарын байдлаар халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх боомын вакцин-8650 үхэрт, дуутын вакцин-4100 толгойд, шөвөг яр-14500 толгой төлд, гахайн мялзан-300 толгойд тус тус хийж 2018 онд мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний гэрээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Празиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд туулгалт-47400 бог, 14900 бодод, боловсруулалт-6650 толгой бодод, 38700 толгой богт хийснээс гадна хонины цэцэг өвчний вакцинныг сумын бүх хонинд хийхээр төлөвлөн ажиллаж байна. Мөн 2018 онд улсын хэмээнд малын гоц халдварт шүлхий өвчин гарсан тул вакцинжуулах ажил хийгдэж одоогоор сумын 440 өрхийн 15865 үхрийг шүлхий өвчний эсрэг вакцинаар тарих ажил хийгдэж ажлын гүйцэтгэл 97,2%-тай хийгдээд байна. Сумын нутаг дэвсгэрт өнгөрсөн өвөл цас их хэмжээгээр орж, шуурснаас болж өвөлжилтийн байдал хүндэрсэн энэ хүнд цаг үед тус сумын ЗДТГ-ын санаачлагаар малчин, мал бүхий иргэддээ нийт давхацсан тоогоор 549 малчин өрх буюу сумын хэмжээнд байгаа малчин, мал бүхий иргэдийн 80% нь хамрагдсан байна.



Швейцарийн хөгжлийн агентлагаас хэрэгжүүлж байгаа БАХ \Бэлчээр ашиглах хэсэг\ байгуулах “Ногоон алт” хөтөлбөрт хамрагдсан тул сум орон нутагт уг ажлыг зохион байгуулан бэлчээрийн хүртээжийг сайжруулах ажлыг хэрэгжүүлэхээр малчдын саналд тулгуурлан сургалт сурталчилгааны ажлыг хийж одоогийн байдлаар бэлчээр ашиглалтын хоёр хэсэг үйл ажиллагаандаа ороод байна. Үүнд “Чулуут баялаг” БАХ, “Ихэр гацаа” БАХ тус тус байгуулагдан цаашдын үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллахаар хэсгийн хурлыг зохион байгуулаад байна.

2018 онд Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс “Эрчимжсэн үхрийн аж ахуй” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс сайн үүлдрийн бух нийлүүлэх ажлын хүрээнд суманд 20 бух авахаар захиалгаа хүргүүлсэн. Өнөөдрийн байдлаар тус суманд цэвэр эрлийз үүлдрийн Сэлэнгэ үхэр-13460, Алатау үүлдрийн үхэр-68, Хар тарлан үүлдрийн үхэр-26, Герефорд үүлдрийн үхэр-8 толгой байна. Энэ нь нийт үхрийн 69,5%-ийг эзэлж байна. Цэвэр эрлийз үхрийн 99,2% Сэлэнгэ үүлдэр 0,6% Алатау 0,2%-ийг хар тарлан үүлдрийн үхэр эзэлж байна. Энэ онд суманд үржүүлж байгаа үхэр сүргийн үүлдэрлэг байдал түүний ашиг шимийн гарцыг тогтоох ажлыг хийж эхлээд байна. Үүнд: ямааны ноолуурын гарц 2018 онд нийлээд сайн нэг ямаанаас 325 гр ноолуур авсан дүнтэй байна. Малын чанар ашиг шимийг нь сайжруулах, Сэлэнгэ үүлдрийн үхрийн генфондыг хамгаалах чанарыг сайжруулах зорилгоор үхэрт зохиомол хээлтүүлэг хийх ажлыг хэрэгжүүлэн ажилсанаар гарсан тугалын амьдын жин нутгийн үхрийн тугалын жингээс даруй 4-6 кг-аар илүү байгаа нь цаашид уг ажлыг хэрэгжүүлэн олон тооны малыг хамруулах шаардлага тулгарч байна. Мөн малчид иргэдийн үндэсний үйлдвэрт тушаасан ноос, арьс ширний падааныг авч тусгай программд шивж холбогдох газруудад хүргүүлэн ажилсан.

Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор нийт 425 малчны 472 ш ноосны падааныг, 251 малчны 605 ш арьс ширний падааныг хүлээн авч холбогдох газарт хүргүүлэн дээрх малчид иргэдийг улсын үйлдвэрт тушаасан бүтээгдэхүүний урамшуулалд хамрагдах нөхцөлөөр ханган ажиллалаа.

5-р сарын 30-ны байдлаар улаан буудай-7800 га-д, рапс-1500 га-д, эрдэнэ шиш-50 га-д, цагаан будаа-4 га-д, төмс-7,0 га-д, хүнсний ногоо-20,9 га-д тус тус тариалаад байна.ТЭДСангийнГазар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх гол түүхий эд болох ургамал хамгааллын бодис бордоог урьдчилгаанөхцөлтэйгээр намар бүтээгдэхүүнээрээ төлөх гэрээгээр нийлүүлэн хийх 17 иргэн 18 ААН-тэй хамтран ажилласан байна. Мөн ТЭДСангийн хөнгөлөлттэй, урьдчилгаатай 6х20 хэмжээтэй хүлэмжийг зээлээр 5 иргэн авч өмнөх 2017 онд 11 хүлэмжинд тариалж байсан бол 2018 онд 45% хувиар хүлэмжийн тариалалт нэмэгдсэн нь хүнсний ногооны тариалалтын нэр төрөл олшрох га-аас авах ургац нэмэгдэх нөхцөл бүрдлээ.

Энэ онд улс, аймаг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Рашаант тосгонд 75 хүүхдийн цэцэрлэгийн барилга, сумын Халаалтын төвийн тогоо шинэчлэх, 24-р цэцэрлэгийн дээвэр, хаалганы засвар, сумын Эрүүл мэндийн төвийн морг,гражийн засвар, Рашаант тосгонд Сүү хөргүүрийн танк худалдан авах, Рашаант тосгоны зам засвар, сумын төвд жишиг хороолол, Баянцогт 2-р багт ухаалаг худагны тоног төхөөрөмж худалдан авах, Зөөврийн эхо аппарат худалдан авах зэрэг томоохон хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэхээр батлагдсан. Эдгээр ажлуудаас Баянцогт 2-р багт ухаалаг худагны тоног төхөөрөмж худалдан авах 13,0 сая төгрөгийг төсөвт өртөгтэй ажил, Рашаант тосгон зам засвар 20,0, 24-р цэцэрлэгийн дээвэр засвар 53,0 сая төгрөгийг төсөвт өртөгтэй худалдан авах ажиллагааг зохион байгуулаад байна. Мөн гатлага онгоц бирваз нь цоорч ус орж ажиллах боломжгүй байсныг 1,5 сая төгрөг гаргаж Засаг даргын Тамгын газрын ажилчдын хүчээр засч ажиллах боломжтой болголоо.

Сумын ЗДТГ, Соёлын төвийн барилгын дээвэр засвар, Соёлын төвийн сантехникийн засвар ажлууд аймгийн хөрөнгө оруулалтаар "Есөн хэлхээ" ХХК гүйцэтгэж гэрээнд заагдсаны дагуу хугацаандаа хүлээлгэн өгсөн байна. Мөн Рашаант Эрүүл мэндийн төвд түргэн тусламжийн машины парк шинэчлэлт хийгдлээ.

Оны эхний 5 сарын байдлаар Шинэ төрсөн-25 хүүхэд, эцэг тогтоолт- 10, Гэрлэлт -9, Нас барсан-8, шилжиж ирсэн-74, шилжиж явсан-70 иргэн байна.

“Шинэ төрсөн хүүхэд,эх”-д хүндэтгэл үзүүлэх журам”-ын дагуу 25эх, хүүхдэд хүндэтгэл үзүүлж баталсан төсвөөс 500,000 төгрөг зарцуулсан байна.

Нийгмийн даатгалын төвлөрсөн санд 5-р сарын байдлаар ажил олгогч даатгуулагчаас 148745,4мянган төгрөгний шимтгэлийн орлогыг төвлөрсөн санд оруулж төлөвлөөг 94,8 хувьтай биелүүлэн ажилласан.

Сайн дурын даатгалд 2018 онд шинээр 40 даатгуулагч, нийт 163 даатгуулагчаас 34956,6 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалд малчин -118, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн -78, оюутан-20 нийт 216 даатгуулагч хамрагдаж 9343,7 мянган төгрөгний орлого оруулж ажиллалаа.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллага нь сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг 5 бүлэг 21 багш, ажилчдын орон тоотой, орон нутгийнхаа өөрийн тойргийн 130 хүүхэд, малчдын 39 хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох, сургалт хүмүүжил, хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагааг амжилттай зохион байгуулан ажиллаж байна. Сумын хэмжээний хамран сургалт 93 хувьтай байна.

Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, зуны цэцэрлэгийг орон нутагт ажиллуулах, малчдын хүүхдийг сургуульд элсэн суралцах боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд 2-5 насны малчдын хүүхдийн судалгааг урьдчилан гаргаж Шар-Ус болон Ар булагт сургуулийн өмнөх боловсролыг 2-5 насны хүүхдүүдэд зуны хувилбарт сургалтыг зохион байгуулахаар ажиллаж байна.

Сумын хэмжээнд ерөнхий боловсролын сургуульд нийт 590 хүүхэд суралцаж 2017-2018 оны хичээлийн жилд 1-р сургууль дээр 5 төрлийн секц, дугуйланд давхардсан тоогоор 175 хүүхэд хамрагдаж сурагчдын 64.8% нь өөрийгөө хөгжүүлэх дугуйлан, секцэнд 2-р сургууль дээр 7 төрлийн секц, дугуйланд давхардсан тоогоор 173 сурагч хамрагдаж байна.

Тайлангийн хугацаанд эх, хүүхдийн эндэгдэлгүй ажиллаж байна. Сумын хэмжээнд 23 жирэмсэн эх хяналтанд байгаагаас Рашаант Эрүүл мэндийн төвд эмнэлэгт 5 эх төрсөн байна.

### **Сант:**

Сумын хэмжээнд 5 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар төллөвөл зохих 41207 эх малаас 32197 толгой мал төллөж, мал төллөлт 78,1 хувьтай байна. Үүнээс гүү 418, үнээ 1219, эм хонь 18100, ямаа 12460 төллөж, төл бойжилт 99,9 хувь буюу 32153 төл бойжиж байна. Том малын зүй бус хорогдол адуу 8, үхэр 93, хонь 48, ямаа 30, нийт 179 толгой том мал хорогдсон нь нийт малын 0,2 хувийг эзлэж байна.

Хаврын тариалалтын ажил эхэлж сумын хэмжээнд үр тариа 3052 га буюу 87,2 %, төмс 185 га буюу 92,5%, хүнсний ногоо 65,05 га буюу 52 %-тай тариалсан. Монгол улсын Засгийн газрын “Хүнсний ногоо” хөтөлбөрийн хүрээнд ХХААХҮЯ-аас хуваарилагдаж ирсэн лууван, хүрэн манжин, шар манжин, ногоон сонгино, гоньд, амтат чинжүү, сармис зэрэг 7 төрлийн ногооны үрийг 36 иргэнд хуваарилан өгч, “Жимс жимсгэнэ” хөтөлбөрийн хүрээнд иргэдийн захиалгын дагуу чацаргана, үхрийн нүд зэрэг жимсний 411000 төгрөгийн 137 ширхэг суулгацыг Дархан-Уул аймгийн Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнгээс авчирч 5 иргэнийг суулгацаар хангасан байна.

Эрчимжсэн мал аж ахуй газар тариалангийн бүс нутагт баримтлах бодлого чиглэлийг хэрэгжүүлэх, сумын төвийн бэлчээрийн даац багтаамжийг нэмэгдүүлэн тохижилт соёлжилтыг сайжруулах ажлын хүрээнд сумын ИТХ-ын 2018 оны 5 сарын 16-ны өдрийн 48 тоот тогтоолоор бог толгойд шилжүүлснээр 300-аас дээш толгой малтай өрхүүдийг сумын төвөөс гарган бэлчээрийг чөлөөлөх ажлыг хийж байна. Мөн бэлчээрийн мэрэгчидтэй байгаль орчинд халгүй аргаар тэмцэх ажлыг 3000 га талбайд хийхээр 2 бүлэг гарган ажиллаж ажлын гүйцэтгэл 20 хувьтай байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар бүх нийтээр мод тарих өдрийг угтаж сумын хэмжээнд 5 ААНБ, 78 хүн оролцож 5 төрлийн 198 ширхэг мод тарьсан байна.

ЗДТГ-ын хамт олон 3 төрлийн 90 гаруй модны суулгац тарьж ногоон байгууламжаа нэмэгдүүлсэн.

Аймгийн ИТХ-ын 31 тоот тогтоолоор батлагдсан “Манай гудамж - Миний гэр” хөтөлбөр болон сумын 90 жилийн ойн бэлтгэл ажлын нэг болох “Эрүүл орчин, хог хаягдал, соёлжилт, тохижилт, ногоон байгууламж” 90 хоногийн аяныг хүрээнд Ивэн, Хушаат багийн нийт 24 гудамжийг цэгцэлж өнгө үзэмжийг сайжруулах арга хэмжээ авлаа.

Сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан сургууль цэцэрлэгийн хоол хүнсний эрүүл аюулгүй байдалд хяналт тавих орон тооны бус зөвлөл ЕБС-ын үдийн цай хөтөлбөр, дотуур байрны хүүхдийн хоол хүнс, 13-р цэцэрлэгийн гал тогоонд зөвлөн туслах үзлэг шалгалт хийж, барилга байгууламжийн стандарт эрүүл ахуй, ажиллагсадын ариун цэвэр эрүүл ахуй, угаалга цэвэрлэгээ, халдваргүйтэл, халдвараас урьдчилан сэргийлэх талаар мөн сургууль цэцэрлэгийн эмчийн үйл ажиллагаатай танилцаж удирдлага арга зүйн зөвлөмж мэдээлэл өглөө.

Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан гэр бүлийн үнэ цэнийг ойлгуулах, гэр бүлийн харилцааны эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгоор "Миний гэр бүлийн нэг өдөр" ЭССЭ бичлэгийн уралдааныг ЕБС-ын 10 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулж, тэргүүн байранд 10а ангийн сурагч Э.Баяржавхлан, дэд байранд сурагч Э.Батэрдэнэ, гутгаар байранд сурагч Ө.Энхбаатар нар шалгарч сумын Засаг даргын батламж, мөнгөн шагналаар шагналаа.

### **Хушаат сум:**

Сумын "Тариаланчид, ногоочдын зөвлөгөөн"-ийг 4-р сарын 30-ны өдөр зохион байгуулж, 2018 оны хаврын тариалалтын агро зөвлөмжийг өгч цаг уурын нөхцөл байдлыг танилцуулан ногоочдын хоршооноос хүнсний ногооны үр, жимсний модны тарьц суулгац худалдлаа.

Сумын хэмжээний мал төллөлт 25797 төл гарснаас унага 291, тугал 2187, хурга 14885, ишиг 8434 толгой нэмэгдэн эсэн мэнд бойжиж байна. 53 том мал зүй бусаар хорогдсон ба үүнээс адуу 3, үхэр 13, хонь 16, ямаа 21 толгой, төл мөл унага 11, тугал 9, хурга 35, ишиг 48 хорогдсон мэдээтэй байна.

Витнет ТББ “Малын эмийн зохистой хэрэглээ”, Мерси кор ОУБ –ын төслийн зөвлөхүүд Бэлчээр хамгаалал, малын чанар сайжруулалт сэдвээр сургалт хийж 35 малчин хамрагдаж, цөм сүргийн эм ямаа, ухнанд хяналтын самналт, хээлтүүлэгч малд хаврын жигнэлт хийж, цөм сүргийн төлөөс шилэн сонголт хийж 106 өсвөр хээлтүүлэгч шинээр тавьлаа. Мөн Мерси кор ОУБ, “Хөгжлийн шийдэл” ТББ–тай хамтран “Гарааны бизнесийг дэмжих “ төслийн уралдаан зохион байгуулж сумаас 5 баг 25 хүн хамрагдаж Б.Энхтүвшин ахлагчтай баг тэргүүлж 5 сая төгрөгийн санхүүжилтээр шагнагдлаа. Мөн 800-1000 бог малын багтаамжтай хашаа, бод малын хоолой тус бүр нэгийг, мал эмнэлгийн багаж тоног төхөөрөмжийг нийлүүлж 16,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ. Мөн Монгол Улсын Засгийн газрын тогтоол, аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд МЭҮА-ын Нэгдсэн арга хэмжээг Мерси кор ОУБ –тай хамтран 4 зөвлөх, 20 хүнтэй 4 баг гарган богино хугацаанд чанартай зохион байгуулж үхрээс цус авах, боомын вакцин тарих, ээмэгжүүлэх ажлыг хийж, 211 хот айл хамрагдаж 5075 үхрээс цус авч шинжилгээг газар дээр нь хийлээ.

Орхон бүсийн 6 сумын төрийн албан хаагчдын дунд нөхөрсөг уулзалт тэмцээнийг Баруунбүрэн суманд зохион байгуулсан ба Хушаат сумын ЗДТГ-ын хамт олон урлагийн төрөлд 1-р байр, гар бөмбөгийн эмэгтэй төрөлд 2-р байр эзэлсэн амжилт үзүүллээ.

Авто тээвэр , өөрөө явагч хэрэгслийн улсын үзлэг явагдаж нийт 230 автомашин техникийн үзлэгт хамрагдаж, авто машин өөрөө явагч хэрэгслийн албан татварт нийт 7.195.570 төгрөг орууллаа.

Аймаг, сумын ОНХсангийн хөрөнгөөр хийгдэх 11 төрлийн ажлын тендерийг сумын Засаг даргын Тамгын газрын цахим хуудсанд байршуулан мэдээлж, тендер шалгаруулалтыг явууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Хүүхэд хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр", аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүдийн хүрээнд Орхон бүсийн хэмжээнд 14 дэх жилдээ уламжлал болон зохион байгуулагдсан "Бүжгийн ертөнц" наадамд Хушаат сумын Соёлын төвийн дэргэдэх бүжгийн дугуйлангийн "Болор-2" хамтлаг ардын бүжгийн хамтлаг төрөлд Ардын жүжигчин Сэвжидийн дэглэлт "Монгол бүжгийн чуулбар" бүжгээр тэргүүн байр, ардын бүжгийн гоцлол төрөлд М.Марал-эрдэнэ тэргүүн байр, зохиомжит бүжгийн гоцлол төрөлд Б.Болорсайхан гутгаар байр тус тус эзлэн амжилттай оролцлоо.

Тус сумын иргэн Гансүхийн Батцэцэг, Ганбатын Мөнхтуяа нар "Өсвөр үеийн 2018 оны Улсын аварга шалгаруулах жүдо бөхийн тэмцээн"-ээс хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлснээр АНУ-ын Сан Франциско хотод зохиогдох өсвөр үеийн бага олимп, АНУ-ын нээлттэй аварга шалгаруулах тэмцээнүүдэд эх орноо төлөөлөн оролцох эрхтэй боллоо.

Сумын ЕБС "Эко сургууль" хөтөлбөрийн хүрээнд "Мянган бүтээлийн үзэсгэлэн" гаргаж "Бүтээлээр урлахуй, үгээр урлахуй" төрөлд 5-а ангийн хамт олон 1-р байр, эцэг эхийн төрөлд 1-р ангийн эцэг эхийн зөвлөл Г.Чимгээгийн 6 төрлийн ундаа 1-р байр эзлэн сургуулийн үдийн цайны ундаагаар шалгарлаа. Сурагчдын бүтээлээр хог хаягдлаар хийсэн даамаар 7-р ангийн сурагч М.Баярмагнай 1-р байр эзэллээ.

"Үндэсний бичиг соёл, тусгаар тогтнол" уриатайгаар ТАХ, Иргэдийн дунд "Бичиг Соёлын өдөр"-ийг 05-р сарын 01-ээс 7-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлж кириллээс монгол бичиг рүү хөврүүлэх, Уран бичлэгийн уралдаан, үзэсгэлэн, гаргалаа. Мөн Монголын ураг удам уламжлалын холбооны тэргүүн Ш.Энхтуяа багш Соёлын төв, ЗДТГазар, ЕБСургууль, Эрүүл мэндийн төв, Яргуй цэцэрлэг дээр тус тус угийн бичгийн сургалтыг зохион байгуулж, 75 төрийн албан хаагчид хамрагдлаа. Сумын ахмадуудтай хамтарч "Номтой нөхөрлөсөн он жилүүд" ярилцлагыг зохион байгуулж, номын сангаар нийт 45 уншигчдад номоор, орон нутаг судлах танхимаар нийт 66 сурагч, иргэдэд үйлчиллээ.

### **Сүхбаатар сум:**

Мэргэжил сонголт-2018 арга хэмжээ энэ сарын 4-нд болж, нийт 400 гаруй төгсөгч, эцэг эхчүүд хамрагдаж БСШУСЯ-ны мэргэжилтнүүд, их дээд сургуулийн төлөөллүүд, ОХУ-ын Буриад улсын 2 их сургуулийн төлөөлөл оролцож мэдээлэл өглөө.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу "Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг удирдамжийн дагуу тэмдэглэж, Монгол бичгээр зөв, цэвэр сайхан бичигтэнг шалгаруулах ажлыг сургууль бүрт зохион байгуулж, сумын аж ахуйн нэгж байгууллагуудын хаяг, логог монгол, крилл бичгээр бичих хөдөлгөөнийг өрнүүлэх зэрэг арга хэмжээг зохион байгууллаа.

Олон Улсын гэр бүлийн өдрийн хүрээнд сумын шилдэг 9 гэр бүлийг шалгаруулж, өргөмжлөл гардуулах ёслолын арга хэмжээг 5-р сарын 16-ны өдөр зохион байгуулснаас гадна "Гэр бүлийн үнэ цэнэ", "Угийн бичиг хөтлөх" сургалтыг 8 багийн 200 гаруй иргэнд явууллаа.

Сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэд Улаанбаатар хотын UB паласт "Зүрхэндээ нартай хүмүүс бид" уран бүтээлийн тоглолтоо хийж, 5-р сарын 28-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан "Хүслийн жигүүр" урлагийн наадамд оролцлоо. Мөн тайлант сард сумын ахмадын хурал, сумын төрийн албан хаагчдын спортын 6 төрөлтийн тэмцээн, хүүхэд багачуудын дунд "Баянханы хүчтэн" үндэсний бөхийн барилдааныг 3 насны ангилалаар явуулснаас гадна "Сэлэнгийн хавар" нийтийн бүжгийн тэмцээнийг зохион байгууллаа.

Сумын хэмжээнд 5-р сарын байдлаар 8064 эх мал төллөж, 8128 төл хүлээн авч мал төллөлт 80,4 хувьтай, малын малын хорогдол 92 гарсан мэдээтэй байна. Мал амьтны халдварт өвчин, шимэгч хорхой, төлийн өвчнүүд, эрдэс витамин дутагдал, малын эм, түүний хэрэглээний талаар сургалт хийж, мал аж ахуй эрхлэгч 45 иргэнийг хамруулсан. Мал эмнэлэг, эрүүл ахуй, ариутгал халдваргүйжүүлэлтийн сарын аяныг удирдамжийн дагуу зохион байгуулж, 32 өрхийн 2600 толгой малд шөвөг, яр өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин, 47 өрхийн 2800 толгой бод мал, 1200 толгой бог малдп боом өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин, 28 өрхийн 380 толгой гахайд гахайн мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг хийж, мал бүхий иргэдийн өвөлжөө, хаваржааны ойр орчим, гуу жалга, хогийн цэгт хаягдсан мал амьтны 23 сэг зэмийг цуглуулж, булж устгах ажлыг хийлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу “Мод тарих үндэсний өдөр”-ийг 5-р сарын 18-нд зохион байгуулж, 18 аж ахуйн нэгж, байгууллага 117 айл өрх, 670 гаруй иргэн оролцож 3520 ширхэг мод, бут сөөг, 70 м<sup>2</sup> газар зүлэг, 5 мянган ширхэг цэцэг тарьж, 8 ширхэг цэцгийн мандал хийлээ.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор Ойн тухай хууль, гамшгаас хамгаалах тухай хууль, амьтны тухай хууль, түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулиудыг сурталчилж, санамж, сэрэмжлүүлгийг өгч ажиллалаа.

### **Түшиг сум:**

Сумын Засаг даргын Тамгын газар, эрүүл мэндийн төв, Соёлын төв, Мал эмнэлэг үржлийн нэгжүүдтэй хамтран 5-р сарын 18-ны өдөр “Явуулын иргэний танхим болон Малчдын өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулж, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтууд, хөрсний элэгдэл бохирдол, мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийг суртчилан цаг үеийн мэдээллийг хүргэж, “Мэдээлэх хуудас”-ыг нийт 68 малчин өрхөд тараалаа. аймгийн Улаан загалмайн хорооны тусламжтайгаар “Орон нутгийн малчид болон хөдөөгийн суурин хүн амын гамшгийн даван туулах чадварыг бэхжүүлэх” төслийн хүрээнд гамшгийн бэлэн байдлыг хангах нийт 8,9 сая төгрөгийн үнэ бүхий багаж хэрэгслийг нийлүүллээ.

Орон нутгийн гамшгийн эрсдлийг бууруулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах “Бэлэн бай” сургалтыг хуваарийндагуу зохион байгуулж, мэргэжлийн анги бие бүрэлдэхүүнд “Газар хөдлөлт түүний хор уршиг”, “Аянга цахилгаан” зэрэг сэдвээр сургалт зохион байгуулж, нийт 38 иргэн хамрагдлаа.

Аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулагдаж буй “Ахмадын урлагийн их наадам”-ын 1 дүгээр шатны шалгаруулалтанд “Урлагаар жигүүрлэсэн ахмадууд” урлагийн арга хэмжээг сумын Соёлын төвд зохион байгууллаа.

5-р сарын 25-ны байдлаар сумын хэмжээнд үр тарианы тариалалт 13241,1 га-д тариалалт хийхээс 6937га-д тариалалт хийж 69,37%-тай, төмс 25 га-д тариалалт хийгдэхээс 10 га-д тариалалт хийж 2.5% тай байна.

Сумын хэмжээнд нийт 20757 толгой эх мал төллөж, төллөх эх малын 75% нь төллөсөн, төлийн хорогдол 0.9%-тай байна. Монгол Ви И Ти Нет ТББ-тай хамтран орон нутгийн “Малын эрүүл мэнд” сургалтыг малчин болон мал бүхий 75 иргэнд зохион байгуулж, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ явуулах аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор мал сүргийг халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг тус суманд үйл ажиллагаа явуулж буй “Номтын-Өндөр”, “Хонгор овоо”, “Мөнх-Зэлтэр” мал эмнэлэг үржлийн нэгж /МЭҮН/-д технологит хугацаандаа шөвөг ярын вакцин 13000 толгой хурга, ишгэнд, булчин цайх 10800 хурга, ишгэнд, Боом 845 тогой бод, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 33470 толгой малд туулгалт хийгдсэн.

Ой хээрийн түймэр, гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд малчин айл өрхийн өвөлжөө хаваржааны хашаа, саравчинд дутуу унтраасан малын өтөг бууцыг айл өрх бүрээр шалган ажиллалаа. Мөн мал аж ахуй эрхэлж буй аж ахуйн нэгжийн 240 гаруй иргэнд анхааруулга, санамж хуудас тараан баталгаажуулсан. Малчин айл

өрхүүдийг хуваарийн дагуу зусч, хаваржих талаар мэдэгдэх хуудас өгч хуваарьтай газруудад буулгах ажлыг зохион байгуулж ажилласан. Мөн тариалангийн талбайн ойр орчимд хаваржиж байсан 23 өрхөд мэдэгдэх хуудас өгч хуваарьт газар нүүлгэх арга хэмжээ авч ажилласан.

“Хар горхи”-д Улаанбаатар Төмөр Замын харьяа мод боловсруулах үйлдвэр 2018 онд олгосон модны хуваарийн дагуу 20 га-д ойжуулалт хийх ажлыг гүйцэтгүүлсэн.

Аймгийн төв Сүхбаатар сумын 1-р сургууль дээр жил болгон уламжлал болгон зохион явуулдаг “Стандарт олимпиад”-д тус сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2-12-р ангийн нийт 67 сурагчид оролцсоноос 2а ангийн сурагч Д.Баярцогт “математик” хичээлээр 3-р байр, 8а ангийн сурагч Б.Дөлгөөн “Монгол хэл” хичээлээр 3-р байр, 10а ангийн сурагч О.Номин “Монгол хэл” хичээлээр 3-р байр тус тус эзэлсэн амжилттай байна.

Амбулатороор 178 иргэн үйлчлүүлэхээс урьдчилан сэргийлэх үзлэгээр 85 хүн хамрагдаж урьдчилан сэргийлэх үзлэг 58%-тай байна.

### **Шаамар сум:**

Гэр бүлийн эерэг харилцаа хандлага, төлөвшил, үлгэр дууриаллыг өсвөр үе залуучуудад болон нийгэмд түгээн дэлгэрүүлэх, хүүхдээ зөв хүн болгон төлөвшүүлэхэд хувь хүн бүрийн оролцоог дэмжих зорилгоор “Олон Улсын гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан “Аз жаргалтай гэр бүл” өдөрлөгийг “Хүүхэд гэр бүлдээ жаргалтай” уриан дор 5-р сарын 15-нд сумын соёлын төвд зохион байгуулж, ЕБС-ын бага ангийн сурагчдын дунд “Аз жаргалтай гэр бүл”, дунд ангийн сурагчдын дунд “Гэр бүлийн аз жаргалын дайсан гэж юу вэ?” сэдвээр гар зургийн уралдаан, ахлах ангийн сурагчдын дунд “Аз жаргалтай гэр бүл таны бодлоор” ЭССЭ бичлэгийн уралдаануудыг тус тус явууллаа.

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хүүхэд багачуудын авьяас чадварыг нээн илрүүлэх, уран бүтээлийг хөхүүлэн дэмжих зорилгоор сумын Засаг даргын ивээл дор бүрэн дунд сургуулийн авьяаслаг сурагч М.Маралмаагийн “Жигүүрлэх нас” тайлан тоглолтыг 4-р сарын 25-ны өдөр зохион байгуулсан.

Сумын орон нутгийн хөрөнгө оруулалтын сангаас хийгдэх ажлын жагсаалтыг сумын ИТХ-аар батлуулж, Дэлгэрхаан 1 дүгээр баг, Охиндий 2 дугаар багуудын зам талбайн ажилд 40,0 сая төгрөг, Дулаанхаан тосгоны 62-р өртөө чиглэлд сайжруулсан зам тавих ажилд 17,0 сая төгрөгийг зарцуулахаар баталсаны дагуу сонгон шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулж, “Сэлэнгэ Есөн-эрдэнэ” ХХК, аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Дулаанхан тосгонд сайжруулсан зам тавих ажлын гүйцэтгэгчээр мөн тус компани шалгарч, ажил гүйцэтгэх гэрээ байгуулан энэ сарын 22-ноос замын ажлууд эхлээд байна. Мөн 2018 оны ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих Охиндий 2-р багийн Хүүхдийн тоглоомын талбайн ажлыг “Титан Оргил” ХХК, Дулаанхаан тосгоны “Ахмадын өргөө” барих ажлыг “Маргад Монгол” ХХК гүйцэтгэж байна.

Тогтвортой амьжиргаа-III төслийн орон нутгийн ажилтан, аймгийн чадавх бэхжүүлэх багийн бүрэлдэхүүн энэ сарын 07-ны өдөр тус суманд ажиллаж орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах сумын ИТХ-ын төлөөлөгчид, багийн ИНХ-ын Тэргүүлэгчид, багийн Засаг дарга нар, хэсгийн ахлагч нар, сумын Засаг даргын захирамжаар ажлын жагсаалт эрэмбэлэх ажлын хэсэг, тендер зохион байгуулах ажлын хэсэгт томилогдсон 40-өөд ажилтан, албан хаагчид болон иргэдийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулж, 2017 оны ОНХС-гийн жилийн гүйцэтгэлийн гүйцэтгэлийн үр дүнг танилцуулж, 2018 онд хийгдэх жилийн үр дүнгийн үзүүлэлтүүдийг хангахад дэмжлэг үзүүллээ.

Сумын нутаг дэвсгэрт цэвэр орчин бүрдүүлэх, орчны эрүүл ахуйн байдлыг сайжруулж, хог хаягдлыг цэвэрлэх зорилгоор 5-р сарын 13-ны өдөр төр төсвийн байгууллагуудын албан хаагчдын дунд бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг зохион



байгуулж, нийт 10 байгууллагын 100 гаруй ажилтан албан хаагчид идэвх санаачлагатай оролцож Шаамар-6 км-ээс сумын төв дундуур дайран өнгөрөх сайжруулсан зам дагуу Орхон голын гүүр, Өндөр хүртэлх газар, Улаанбаатар-Сүхбаатар чиглэлийн авто замын сумын нутаг дэвсгэр дайран өнгөрөх Хөх чулуутаас Сүхбаатар самбар хүртэлх газрын хог хаягдлыг түүж хогийн нэгдсэн цэгт тээвэрлэн хүргүүлж ажиллалаа.

2018 оны 5-р сарын байдлаар сумын хэмжээнд үр тариа 1700 га тариалж 83%, төмс га тариалж 70%, хүнсний ногоо 103 га тариалж 54%-тай явж байна. ХХААХҮ-ийн яамнаас ирүүлсэн 5 нэр төрлийн хүнсний ногооны 30.6 кг үрийг 68 иргэнд хуваарилан олгосон.

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин тарилга, туулгалт, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг 3 багийн нутаг дэвсгэрт “Туяа сан” МЭҮН, “Өсөх Эрдэнэ” МЭҮН, “Даншиг халзан” МЭҮН зэрэг 3 Мал эмнэлэг хариуцан зохион байгууллаа. Сумын хэмжээнд боомын вакцин 5336 бод, 6600 бог, Шөвөг ярын вакциныг 4100 төл малд, бактерин 120 унаганад, нийт 16156 малд малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, вакцин хийсэн. Малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Улаанбаатар хотын “Монгол Ви Ти Нет” ТББ-тай хамтран орон нутгийн малчин мал бүхий иргэдийн дунд “Малын эрүүл мэнд” сэдэвт сургалтын 4-р сарын 30-нд зохион байгуулж, малын эмийн зүй зохистой хэрэглээ, малын багаж төхөөрөмжийн талаар танилцуулга мэдээлэл өгсөн. Сургалтанд малчин мал бүхий өрхийн нийт 63 иргэн хамрагдлаа.

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН :

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ш.ЭНХМАА

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА